



THE WORLD BANK

Стандарт, дүрэм журмын мөрдөлтийн байдалд өгсөн үнэлгээний тайлан (ROSC)

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ
ГИШҮҮН ОРНЫ ҮНЭЛГЭЭ

Монгол Улс



THE WORLD BANK

ROSC

Агуулга

Хураангуй.....	3
I. Судалгааны суурь.....	4
II. Судалгааны гол үр дүн	6
1. Компанийн засаглалын тогтолцоо	6
2. Хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг	9
3. Хувьцаа эзэмшигчдэд тэгш хандах...	12
4. Оролцогч талуудын гүйцэтгэх үүрэг	14
5. Мэдээ мэдээллийг ил болгох, ил тод байдал.....	16
6. ТУЗ-ийн үүрэг хариуцлага.....	20
III. Тойм хүснэгт, график	23
IV. Зөвлөмж, үйл ажиллагааны төлөвлөгөө	24
Хавсралтууд	25



Report on the Observance of Standards and Codes (ROSC)

ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Компанийн засаглалын хууль эрх зүй, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр Монгол Улсын Засгийн газар томоохон үр дүнд хүрээд байгаа билээ. Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) Монгол Улсын компанийн засаглалын дүрмийг (МУКЗД) 2007 онд баталж, Монголбанк (МБ)-наас компанийн засаглалын багц журмыг мөрдүүлж эхэлсэн. Мөн түүнчлэн Компанийн тухай хуулийг боловсронгуй болгох хэд хэдэн нэмэлт өөрчлөлтүүд хийгдэж, Үнэт цаасны тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулахаар төлөвлөөд байна.

Гэвч Монгол Улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хэрэгжүүлж буй “цаасан дээр буусан хууль” болон компанийн засаглалын хээргжилтийн байдалд томоохон зөрүү байна. Тоймлон хэлбэл:

- ТУЗ-үүдийн ихэнх нь гүйцэтгэх удирдлагыг удирдамжаар хангах буюу үйл ажиллагаанд нь хяналт тавихын оронд компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцож удирдан зохион байгуулдаг. Эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, аудитын үйл ажиллагаа, мэдээ мэдээллийг ил тод болгох, дараалсан төлөвлөлтийн үндсэн бодлого, зарчмууд тодорхойлогдоогүй байна. ТУЗ-ийн гишүүдийг томилох үйл явц далд явагдаж байгаагийн зэрэгцээ ихэнх гишүүдийг томоохон хувь нийлүүлэгч нар томилж байна. Ингэснээр ТУЗ-ийн бүрэлдэхүүнд компанийн дотоод мэдээллийг эзэмшигч этгээд орж, чухал ач холбогдолтой ур чадвар дутагдаж байна.
- Санхүүгийн тайлагналын тогтолцоо сул хөгжилтэй хэвээр байна. СЗХ-ноос 2007 онд явуулсан судалгаагаар нийт 380 компанийн 138 буюу 36 хувь нь санхүүгийн тайлан тэнцлээ гаргаж хүргүүлсэн байна. 2008 онд Дэлхийн Банкнаас гаргасан Нягтлан бодох бүртгэл, аудитын ROSC үнэлгээний тайланд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС)-ын мөрдөлт нилээд хангалтгүй байсныг илрүүлсэн. Санхүүгийн бус мэдээ мэдээллийг ил тод болгох асуудал ч мөн учир дутагдалтай байгаа бөгөөд цөөн хэдэн компаниуд өмчлөл, засаглалын бүтэц зохион байгуулалттай холбоотой мэдээ мэдээллийг нийтэд ил тод болгож байна.
- Хувьцаа эзэмшигчийн үндсэн эрх хангагдахгүй байна. Тухайлбал, СЗХ-ноос явуулсан судалгааны дүнгээр хөрөнгийн биржид бүртгэлтэй 384 компанийн дөнгөж 158 нь хувь нийлүүлэгчдийн хурлаа 2007 онд зарлан хуралдуулсан байна.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэж Монгол Улсын бодлого боловсруулагчид компанийн засаглалын талаар удирдамж өгч, зарим үед засаглалын тогтолцоогоо сайжруулахыг шаардах нь зүйтэй. Тодруулбал, Монгол Улсын Засгийн газар дараах арга хэмжээг авах шаардлагатай байна. Үүнд:

1. *Зохицуулалтыг хэрэгжүүлдэг бүх төрлийн эрх бүхий байгууллагуудад хууль эрх зүй, зохицуулалтын тогтолцооны хэрэгжилтийг хангах талаар хариуцлага тооцдог байх.* Засгийн газрын зүгээс МБ, СЗХ, Монголын хөрөнгийн бирж (МХБ) болон бусад зохицуулалтыг хэрэгжүүлдэг байгууллагуудад шаардлага хөрөнгө нөөцийг гарган өгч, хараат бус бие даасан байдлыг хангаж хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хатуу чанд, тогтмол, шударгаар хангах нөхцлийг бүрдүүлэх ёстой. Хууль дүрэм хэрэгжүүлэгч бүх байгууллагуудын үүрэг роль, тайлагналын тогтолцоо, хариуцлагын хүрээг тодорхой зааж өгөхийн зэрэгцээ хэрэгжүүлэх тал дээр хамтран ажиллаж, хариуцлага тооцох ёстой.
2. *Үйл ажиллагаагаа явуулахгүй байгаа, түр зогсоосон, хууль дүрэмийг зөрчсөн бүх компаниудыг бүртгэлээс хасах, нэн ялангуяа МХБ-ид бүртгүүлэх шалгуурыг боловсронгуй болгох замаар зах зээлд итгэх итгэлийг сэргээх.* Засгийн газраас хавчин шахах, хяналтын хувьцааг худалдан авах зэрэг эрхийг эдлүүлж, жижиг хувьцаа эзэмшигчдийг томоохон хувьцаа эзэмшигчдэд хувьцаагаа худалдаж шахуулах болон эсрэгээрээ томоохон хувьцаа эзэмшигчдэд жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авч

шахах боломжийг нь гаргаж өгөх нь зүйтэй. Ингэхдээ хувьцааны үнэлгээг шударга тогтоох нөхцлийг бүрдүүлэх ёстой.

3. Компанийн тухай, Банкны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Аудитын тухай, Үнэт цаасны тухай хуулиуд болон холбогдох дүрэм журам, нэн ялангуяа хөрөнгийн биржид бүртгүүлэх журам, МУКЗД-д нэмэлт өөрчлөлт оруулж, *компанийн засаглалын тогтолцоог боловсронгуй болгох.*
4. *Монгол Улсын төрийн өмчит аж ахуйн нэгжийн компанийн засаглалыг боловсронгуй болгох стратегийг боловсруулах.*
5. Чанартай захирал бэлтгэх хөтөлбөрийг боловсруулах, тэдгээрт хөтөлбөрт захирал, менежерүүдийг хамруулах, компанийн сайн засаглалын талаар олон нийтийн дунд мэдээлэл сурталчилгаа явуулж, хөгжүүлэх учир шалтгааныг бий болгох чиглэлээр Монгол Улсын Компанийн засаглалын төв, шинээр үүсэн гарч буй компанийн засаглалын чиглэлийн компаниудын гаргаж буй идэвх санаачлагыг дэмжиж, *чадварлаг захирлуудыг нөөцийг бүрдүүлэх.* Хамгийн гол нь компанийн сайн засаглал гэж юу болох, яагаад чухал болох талаар сайн ойлголттой болгох нь хууль эрх зүй, зохицуулалт, институцийн өөрчлөлт шинэчлэлтийг хэлбэрээс гадна үндсэн агуулгаар нь хэрэгжүүлэх угтвар нөхцөл болж өгдөг билээ.

Удиртгал

Компанийн засаглалын ROSC үнэлгээний тайлангийн хэрэглэгчид, үнэлээний аргачлал ба зорилго

Эдийн засгийн агуулга

Эдийн засгийн тогтвортой өсөлт хүн амыг өргөн хүрээнд хамарч чадаагүй бөгөөд дэлхийн санхүү эдийн засгийн хямралын улмаас буурлаа

Компанийн бүтэц ба хууль эрх зүйн орчин

Хөрөнгийн биржид бүртгэлтэй цөөн тооны компанийг, хэдий хоцрогдсон ч, хууль эрх зүйн зохистой тогтолцоогоор зохицүүлж байна

Хөрөнгийн зах

Хөрөнгийн зах зээл сул хөгжсөн

Компанийн засаглалын ROSC үнэлгээний энэхүү тайлан (цаашид тайлан)-гаар Монгол Улсын хууль эрх зүй, зохицуулалтын тогтолцоо, мөрдөлтийн байдал, хэрэгжилтийг хангах тогтолцоог Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргасан Компанийн засаглалын үндсэн зарчмууд (OECD Зарчмууд)-тай харьцуулахад ямар шатанд байгааг харуулах болно. OECD Зарчмууд нь компанийн сайн засаглалын олон улсын жишгийг тогтоож өгдөг юм. OECD зарчмууд болон өргөн утгаараа энэхүү тайлан нь санхүүгийн болоод санхүүгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг, хувьцаа нь хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагддаг компаниудад чиглэсэн хэдий ч хөрөнгийн биржид бүртгэлгүй томоохон хувьцаат компани, төрийн өмчит аж ахуйн нэгжүүд зэрэг олон нийтийн ашиг сонирхол бүхий бусад байгууллагын үнэлгээнд ижил хэмжээгээр ашиглах боломжтой.¹ Энэхүү тайлангийн үндэс нь Дэлхийн Банкнаас боловсруулсан 700 гаруй тоон мэдээн дээр суурилсан шинжилгээний загвар байсан бөгөөд Монгол Улсын энэ асуудалд хувь сонирхол бүхий бусад байгууллагуудтай хийсэн уулзалт ярилцлагаас олж авсан чанарын агуулгатай мэдээ мэдээллээр баяжуулсан билээ.

Энэхүү үнэлгээний ажлыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны санаачлага, захиалгаар хийж гүйцэтгэсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газар болон компанийн засаглалын бодлогыг тодорхойлогч бусад байгууллагад үндсэндээ зориулсан. Хөрөнгө оруулагчид, компаниуд өөрсдөө зэрэг сонирхлыг бусад этгээдийн хувьд компанийн сайн засаглалын үнэлгээ хийх, түүнийг хэрэгжүүлэх асуудлаар энэхүү тайлан чухал аж холбогдолтой байх болно.

Монгол Улс зах зээлийн эдийн засагт суурилсан эдийн засаг уруу шилжихдээ томоохон амжилт гаргаж, бүтцийн шинэчлэлийг хэрэгжүүлэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр чухал үр дүнд хүрч чадсан. Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2002 оноос хойш тогтвортой өсөж, жилийн өсөлт дунджаар 7.5 хувь байсан. 2007 онд ДНБ хамгийн ихээр буюу 10.2 хувиар өссөн бол 2008 онд урьдчилсан гүйцэтгэлээр 8.9 хувиар өссөн нь чамлахаар үзүүлэлт биш юм. Эдийн засгийн өсөлт бараа түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнээс шууд хамааралтай байдаг бөгөөд өсөлт хэдий ийм өндөр байсан ч амьжиргааны түвшнээс доогуур орлоготой хүн амын хувь хэмжээнд өөрчлөлт ороогүй юм. 1998 оноос хойш ядуурлын үзүүлэлт 32-36 хувьтай байлаа. 2008 онд нэг хүнд ногдох ДНБ 1,981 ам. доллар байсныг хоёр хөрштэй нь харьцуулбал ОХУ-д 11,807 ам. доллар, БНХАУ-д 3,315 ам. доллар байв. Дэлхий нийтийг хамарсан хүнс, санхүүгийн хямрал Монгол Улсын эдийн засагт олон талаар нөлөөлж, инфляцийн түвшин 2008 оны 8-р сард 34.1 хувь хүртэл нэмэгдсэн (гэхдээ 2009 оны 4-р сарын байдлаар инфляци 12.6 хувь болж буураад байгаа). Мөн түүнчлэн 2007 оны 1-р сард 2,057 пункт дээр байсан хөрөнгийн биржийн индекс 9-р сар гэхэд 13,5192-д хүрч 2009 оны 6-р сард 4,740 болж буурсан. ДНБ-ий жилийн бодит өсөлт 2009 оны эхний улиралд 4.2 хувь болсон бөгөөд 2009 онд ДНБ-ий өсөлт 2.7 хувь болно гэсэн төсөөлөл бий.

Монгол Улсад 50,000 орчим бие даасан аж ахуйн нэгжүүд байдгийн 37,000 нь идэвхтэй үйл ажиллагаатай гэж тооцогддог. Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу ерөнхий бөгөөд хязгаарлагдмал нөхөрлөл, хоршоо, хязгаарлагдмал хариуцлагатай компани, хувьцаат компани байгуулж болно. 2007 оны 12-р сарын байдлаар 384 хувьцаат компани Монголын Хөрөнгийн Бирж (МХБ) дээр бүртгэлтэй байсан. Санхүүгийн зах зээлийн хувьд 16 арилжааны банк, 137 банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байна.

Компанийн засаглалын хууль эрх зүй, зохицуулалтын тогтолцоо харьцангуй дээд түвшинд бүрдсэн бөгөөд Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн хөгжлийн түвшинтэй нийцэж байна. Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль, Банкны тухай

¹ Өөрөөр тодорхойлоогүй бол энэхүү тайланд компани гэдэгт МХБ дээр бүртгэлтэй бөгөөд хувьцаагаа арилждаг Монголын бүх компаниудыг хамруулж ойлгоно.

хууль, Банк бус санхүүгийн байгууллагын тухай хууль зэрэг компанийн засаглалтай холбоотой ихэнх гол хууль тогтоомжууд, тусгай журмууд, тэр дундаа хөрөнгийн биржид бүртгэх журам батлагдан мөрдөгдөж байгаа бөгөөд нийтлэг жишигт нийцсэн олон зүйл заалтуудыг багтаасан байна. Ерөнхий тогтолцоо үндсэндээ эрх зүйт төрийн зарчим дээр суурилж, Монгол Улсыг зах зээлийн эдийн засаг уруу шилжүүлэхэд дэмжлэг болоод зогсохгүй эдийн засгийн өсөлтийг ерөнхийдөө дэмжиж ирсэн хэдий ч компанийн засаглалын хууль эрх зүй, зохицуулалтын орчин хоцрогдсон, мөн хуулийн зарим зүйл заалтууд хоорондоо харшилсан зэрэг шүүмжлэлд өртөж байсан нь үндэслэлтэй юм.

Монгол Улсад хөрөнгийн зах сайн хөгжөөгүй хэвээр байна. Зах зээлийн хөрөнгөжилт, арилжааны дүн, хэмжээ, хөрвөх чадвар харьцангуй бага байна. 2000 оноос хойш МХБ дээр жилдээ дунджаар 5 компани шинээр бүртгүүлж, 9 компани бүртгэлээс хасагдсан. Хувьцааны захын хөрөнгөжилт өсөж байсан хэдий ч (Зураг 1) зах зээлийн нийт хөрөнгөжилт, идэвхтэй арилжааны ихэнх хэсгийг цөөн хэдэн хувьцаа эзэлж байна. Мөн түүнчлэн хувьцааны арилжаа Монголын томоохон компаниудыг багтаасан МХБ-20 индекс дээр төвлөрөн хийгдэж байна. 1990 оны эхээр өмч хувьчлалын хүрээнд хөрөнгийн биржид анх бүртгэлтэй болсон олон тооны компаниуд одоо хясаа төдий зүйл болжээ.² Үүнтэй холбогдуулан нэг зүйлийг дурьдахад Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ноос 2007 оны 11-р сард хөрөнгийн биржид бүртгэлтэй 384 компаниас 200-г нь бүртгэлээс хасах шийдвэр гаргаж, бат бөх хөрөнгийн захыг хөгжүүлж, МХБ-ийн нэр хүндийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Гэвч уг шийдвэрээ дараа нь цуцалсан.


Өмчлөл

Өмчлөл төрийн мэдэлд төвлөрсөн хэвээр байна

МХБ дээр бүртгэлтэй компаниудын 21 буюу 5.5 хувь 100 хувь төрийн өмчит аж ахуйн нэгжүүд, 35 буюу 9.1 хувь нь төрийн өмчийн оролцоотой, үлдсэн 328 буюу 85.4 хувь нь хувийн компаниуд байна. МХБ дээр бүртгэлтэй байгаа 2.5 тэрбум ширхэг

хувьцааны 1.9 тэрбум ширхэг буюу 74.5 хувийг төр эзэмшиж, 636 сая ширхэг буюу 25.5 хувь нь хувь хүмүүсийн мэдэлд байна.³ Чухамдаа, хувийн өмчит компаниудын ихэнх нь харьцангуй жижиг хэмжээтэйд тооцогддог. Зах зээлд оролцогчдын тооцоолж байгаагаар хувийн өмч давамгайлсан компаниудын өмчлөл нилээд их төвлөрсөн бөгөөд энгийн хувьцааны 70 орчим хувийг 1-3 хувь хүн эзэмшиж байна. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн компанийн засаглалын тогтолцоо, мөрдөлт, нэн ялангуяа ТУЗ-ийн үйл ажиллагаа, мэдээллийг нийтэд танилцуулах, хяналтын тогтолцооны хувьд сул хөгжсөн хэмээн зах зээлд оролцогчдын олонхи үзэж байна. Банкны салбарын хувьд гадаадын хувь оролцоо нилээд өндөр бөгөөд жирийн компани, төрийн өмчит аж ахуйн нэгжийнхтэй харьцуулахад банкны засаглал илүү өндөр түвшинд хөгжсөн хэдий ч олон улсын шилдэг туршлагаас хоцорсон хэвээр байна. Засгийн газрын тэтгэврийн сан зэрэг зохион байгуулалттай дотоодын хөрөнгө оруулагч нар Монголын компаниудад хөрөнгө оруулах чиглэлээр тодорхой үүрэг гүйцэтгэдэггүй. Жижиг хувьцаа эзэмшигчид нь ихэнх тохиолдолд одоо ажиллаж

Figure 1: Market data: 2000 to 2008



Институцийн хүрээ

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах эрх бүхий гол байгууллагууд ажиллаж байна

² 2007 онд СЗХ-ноос гаргасан тайланд санхүүгийн болоод үйл ажиллагааны хүндрэлд орсон 62, төлбөрийн чадваргүй 146 компани байсан ба эдгээрийн 67 хувийнх нь өөрийн хөрөнгө зориулалт бусаар ашиглагдсан байжээ.

³ МХБ-ийн 2007 оны Factbook. www.mse.mn/ хаягаар орно уу.

байгаа болон өмнө нь ажиллаж байсан хүмүүс байдаг бөгөөд 1990-ээд оны нийтийг хамарсан өмч хувьчлалын хүрээнд хувьцааг нь эзэмшиж эхэлсэн байдаг. Жижиг хувьцаа эзэмшигчдийн ихэнх нь хувьцаа эзэмшигчийн эрхийн талаар ойлголтгүйгээс гадна хувьцаа эзэмшигч гэдгээ ч мэддэггүй хүмүүс байдаг байна.

Компанийн засаглалтай холбоотой хууль дүрмийг Монгол Улсад сахиулагч үндсэн байгууллагууд нь Сангийн яам, СЗХ, Монголбанк (МБ), МХБ, Үнэт цаасны төлбөр тооцоо, нэгдсэн хадгаламжийн төв болон Монгол Улсын Мэргэшсэн нягтлан бодогчдын хүрээлэн (МУМНБХ) юм. Сангийн яаманд олон үүрэг оногддогийн нэг нь нягтлан бодох бүртгэл, аудитын стандартыг мөрдүүлэх юм. МБ-ны хувьд Банкны тухай хууль, банкинд мөрдөгдөх тусгай журмуудын хэрэгжилтийг хангаж ажилладаг. МХБ хөрөнгийн захыг ерөнхийд нь зохион байгуулж, биржид бүртгүүлэх журмыг мөрдүүлдэг. Үнэт цаасны төлбөр тооцоо, нэгдсэн хадгаламжийн компани нь арилжааны төлбөр тооцоог гүйцэтгэдэг бөгөөд нэгдсэн хадгаламжийн үүрэг гүйцэтгэдэг. МУМНБХ бол нягтлан бодох бүртгэл, аудитын стандартыг боловсруулж, шинэчилэхэд туслалцаа дэмжлэг үзүүлдэг өөрийгөө зохицуулагч төрийн бус байгууллага юм.

? Өөрчлөлт шинэчлэлт хийх хүсэл эрмэлзэл
Илүү их хүсэл эрмэлзэл гаргаж бодитоор хэрэгжүүлж чадахаа харуулах ёстой

Монгол Улсын төр засаг компанийн засаглалыг бэхжүүлэх ихээхэн сонирхолтой байгаа бөгөөд шаардлага арга хэмжээг авах эрмэлзэл дүүрэн байгаа мэдэгдсэн. Тухайлбал, OECD-ийн Компаний засаглалын зарчмуудыг монгол хэлнээ орчуулж, компанийн засаглалын дүрмийг СЗХ-ноос 2007 онд батлан гаргаж, МБ компанийн засаглалтай холбоотой журмыг батлаад байна. Цаашилбал, компанийн засаглалын тухай асуудал, нэн ялангуяа Монгол Улсын Компанийн засаглалын дүрмийг ухуулан сурталчлах чиглэлээр хэд хэдэн арга хэмжээг зохион байгуулаад байна. Эцэст нь Монгол Улсын Компанийн засаглалын форум, Компанийн засаглалын хүрээлэн саяхан байгуулагдаж компанийн засаглалыг сайжруулах чиглэлтэйгээр ажиллаж байна. Гэвч эдгээр санал санаачлагуудын ихэнхийг олон улсын болоод хоёр талт хандивын байгууллагууд эхлүүлж хэрэгжүүлсэн байна.

CHAPTER I

Ensuring for an Effective Corporate Governance Framework

Хэрэгжилтийн байдалд хийсэн шинжилгээ

Зарчим I.A.: Компанийн засаглалын тогтолцоо нь эдийн засгийн ерөнхий төлөв, зах зээлийн шударга зарчим, түүний хөшүүрэг, тунгалаг бөгөөд үр ашигтай зах зээлд нөлөөлж байх ёстой.
Хэрэгжилтийн байдал:
Хэсэгчлэн хэрэгжсэн

Зарчим I.B.: Компанийн засаглалын хууль тогтоомж, дүрэм журмууд нь хууль дээд ёсонд нийцэж байх бөгөөд тунгалаг, мөрдүүлэх боломжтой байх ёстой.
Хэрэгжилтийн байдал:
Хэсэгчлэн хэрэгжсэн

Монгол Улс OECD Зарчмуудын 1-р бүлгийг хэсэгчлэн хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

Хөрөнгийн захын үйл ажиллагаа бодитой тунгалагт тооцогддоггүй. Компанийн засаглалын тогтолцооны хүрээнд санхүүгийн болоод санхүүгийн бус мэдээллийг нийтэд танилцуулж байгаа байдал болон ил тод байдал өндөр түвшинд хангагдахгүй байна (5-р бүлгийн гол үр дүнг харна уу). Зах зээлийн олон оролцогчдын хувьд дотоод мэдээллийг ашиглаж биржийн арилжаанд оролцох, зах зээлийн нөхцлийг гуйвуулах нь санаа зовоосон асуудал хэвээр байна. Цаашилбал, зах зээлийн зуучлагчдын үйл ажиллагаа тунгалаг байж чадахгүй байна.

Эрх бүхий байгууллагууд бодлого, хууль тогтоомж, дүрэм журам боловсруулахдаа оролцогч талуудтай харилцан зөвлөлддөггүй. Эрх бүхий зарим байгууллагаас өргөн барьсан хуулийн төслийг УИХ-ын цахим хуудсан дээр байрлуулдаг, мөн СЗХ-ны цахим хуудсан дээр “бодлогын хэлэлцүүлэг” нэртэй булантай, өөрийн боловсруулсан журмын төслийг олон нийтийн хэлэлцүүлэгт зориулын Интернет дээр тавьдаг хэдий ч засгийн газрын ихэнх агентлаг байгууллагууд нийтлэг жишгээс хоцорч, санал дүгнэлт авах, санал гомдол, дэмжлэг олох авах зорилготой дугуй ширээний арга хэмжээ зохион байгуулах, санал дүгнэлтийг Интернет дээр тавьдаггүй.⁴ Тухайлбал, МУКЗД-ийн төслийг Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны ажлын хэсэг үндсэндээ боловсруулж гаргасан. СЗХ МУКЗД-ийг 2007 онд баталсан хэдий ч олон нийтийн хэлэлцүүлгийн арга хэмжээ гуравхан удаа зохион байгуулагджээ. Эдгээрт СЗХ, санхүүгийн зуучлагч нар, ТББ-ууд хамрагджээ. Хэлэлцүүлгийн шатанд компаниудыг хамруулаагүй байна.

Хууль эрх зүй, зохицуулалтын орчин бүрэн дүүрэн хэрэгжүүлж чадахгүй байгаагийн зэрэгцээ бүрэн гүйцэд ойлгогдоогүй ч чиглэл нь ерөнхийдөө тодорхой байна. Ихэнх хууль тогтоомж, дүрэм журамтай танилцах боломжтой бөгөөд монгол, англи хэл дээр Интернетээс харах бололцоотой. Монгол Улсын хууль эрх зүй, зохицуулалтын орчинд хуучирсан нэмэлт өөрчлөлтүүд байхгүй. Гэхдээ зохицуулагч байгууллагууд хууль тогтоомж, дүрэм журмыг тогтмол мөрдүүлэхгүй байна. Зах зээлийн хэд хэдэн оролцогчид тэмдэглэж байгаагаар компаниуд буюу хөрөнгө оруулагч нар гол хууль тогтоомж, дүрэм журам, нэн ялангуяа нягтлан бодох бүртгэл, аудитын хууль дүрмийг сайн ойлгож чаддаггүй байна.

Хууль эрх зүй, зохицуулалтын тогтолцоо эрх зүйт төрийн зарчимтай зөрчилдөн дурын агуулга, тогтмол бсу байдлаар хэрэглэгддэггүй ч зарим компанийн хувьд дэндүү нарийн төвөгтэй байна. Төр засгийн байгууллагууд хууль дүрмийг дурын агуулгыг ашигладаггүй ч хэрэгжүүлэх боломжгүй хууль тогтоомж хэд хэд байна. Эдгээр нь Монголын компаниудын хувьд дагаж мөрдөхөд дэндүү нарийн төвөгтэй юм. Ингээд хөрөнгийн биржид бүртгэлгүй хувьцаат компаниуд ер нь бол жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ)-т тооцогдох хэдий ч санхүүгийн тайлан тэнцлээ бэлтгэхдээ Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ыг дагаж мөрдөх үүрэгтэй байгаа нь нийтлэг жишигт нийцэхгүй байна. Ерөнхийд нь дүгнэж үзвэл, Монгол Улс Дэлхийн Банкны Дэлхийн улс орнуудын засаглалын үзүүлэлтийн төслийн хүрээнд эрх зүйт төрийн хөгжлөөрөө 44 хувийн үзүүлэлттэй байна.⁵

⁴ The Mongolian government recently launched a project "open government" to become more transparent and inclusive. However, this project has since only resulted in a webpage, which is not always operational.

⁵ See <http://info.worldbank.org/governance/wgi>. This “rule of law” indicator measures the extent to which agents have confidence in and abide by the rules of society, *inter alia* the quality of contract enforcement.

МУКЗД-ийн олон зүйл заалтууд нийтлэг жишигт нийцэж байгаа ч бодит байдал дээр мөрдөгдөхгүй байна. МУКЗД-ийг анх МХБ дээр бүртгэлтэй компаниудаар сайн дурын үндсэн дээр мөрдүүлэхээр гаргаж байсан. СЗХ-ноос 2007 онд тогтоол гаргаж МУКЗД-ийг компаниудад “дагаж мөрдөх эсвэл тайлбар өгөх” зарчмаар хэрэгжүүлэхээр болсон.⁶ Гэвч зөвлөлдөх үйл ажиллагааг өргөн хүрээнд хийхгүй байгаагаас ихэнх компаниуд МУКЗД байдгийг мэдэхгүй, улмаар мөрдөлт муу байна. МБ мөн банкуудын засаглалын журмыг 2006 онд мөрдүүлж эхэлсэн. Төрийн өмчийн хороо (ТӨХ) төрийн өмчит аж ахуйн нэгжийн засаглалын журмын төслийг боловсруулж байна.⁷

Зарчим I.C.: Хууль дүрмийн хэрэгжилтийг хангах байгууллагуудын үүрэг хариуцлагын зааг ялгааг тодорхой зааж, олон нийтийн эрх ашгийг хамгаалсан байх. **Хэрэгжсэн байдал:** Хэсэгчлэн хэрэгжсэн

Хууль дүрэм сахиулагч байгууллагууд бодит байдал дээр сайн хамтран ажиллахгүй байгаагийн зэрэгцээ хууль дүрмүүд хоорондоо зөрчилдөх тохиолдлууд байна. Цаашилбал ЖДҮ-үүдийн хувьд хууль дүрмийг дагаж мөрдөх нь өртөг зардал ихтэй байна. Монгол Улсад банк, ББСБ, компани тус бүрт тусгайлан хууль дүрэм байдаг. Эдгээрийг хэрэгжилтийг хангах үүрэгтэй тодорхой байгууллагууд байна. Лизингийн үйл ажиллагаа явуулах хууль эрх зүй, хэрэгжилтийг хангах тогтолцоо сул хөгжсөн байна. Хуулийн дагуу санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах үүднээс⁸ МБ, СЗХ, ТӨХ-ын хооронд харилцан ойлголцоллын гурвалсан меморандум зурах шаардлагатай байдаг бөгөөд 2006 оны 11-р сард эдгээр гурван байгууллагын хооронд үзэглэсэн байгаа. Цаашилбал, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийг МБ-ны ерөнхийлөгч, Сангийн сайд, СЗХ-ны даргын 2007 оны 5-р сарын хамтарсан тушаалаар байгуулж, тэдгээрийн үйл ажиллагааны уялдаа холбоог бэхжүүлэх зорилго агуулсан. Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдалд эрсдэл учруулж буй биржид бүртгэлтэй банк, санхүүгийн группын үйл ажиллагаанд МБ, СЗХ-ны Зохицуулах нэгж хамтарсан шалгалт хийх учиртай. Зохицуулах нэгжийн бүрэлдэхүүнд МБ, СЯ, СЗХ-ны удирдах албан тушаалтнууд багтсан. Гэхдээ хууль дүрэм сахиулагч байгууллагуудын хамтын ажиллагааг бодит байдал дээр бэхжүүлэх шаардлагатай байна.

Зарчим I.D.: Хууль дүрмийн хэрэгжилтийг хангах байгууллагууд чиг үүргээ мэргэжлийн түвшинд бөгөөд ямар нэгэн нөлөөнд авталгүйгээр биелүүлэхэд шаардлагатай эрх мэдэл, нэгдмэл байдал, хөрөнгө нөөцөөр хангуулсан байна. Аливаа шийдвэр нь цагаа олсон, тунгалаг бөгөөд үндэслэлтэй байна. **Хэрэгжсэн байдал:** Хэсэгчлэн хэрэгжсэн

*СЗХ хууль дүрэм сахиулах үйл ажиллагаагаа явуулахын тулд зохих хэмжээний хөрөнгө нөөц, эрх мэдэлтэй болох шаардлагатай байна.*⁹ СЗХ 2006 онд байгуулагдаад удаагүй хэдий ч зах зээлийн оролцогчдын дунд эерэг байр суурь олж авч чадсан. СЗХ нь үйл ажиллагаагаа УИХ-д тайлагнадаг нь нийтлэг жишигт нийцэж байна (СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуулийн 9.1, 10.5-р заалтууд). УИХ мөн СЗХ-ны үйл ажиллагааны төсвийг баталдаг СЗХ-ны төсвийн тал хувийг торгууль, үйлчилгээний хөлсний орлогоос бүрдүүлж үлдсэн талыг улсын төсвөөс санхүүжүүлдэг. Хууль эрх зүйн орчингоор СЗХ-ны үйл ажиллагааны хараат бус бие даасан байдал хангагддаг ч зарим хүмүүс СЗХ Засгийн газрын дарамт шахалтанд орж, хараат бус бие даасан байдлыг алдаж байна гэсэн байр сууриа илэрхийлээд байгаа. СЗХ жилийн тайлан гаргаж, хууль дүрмийг сахиулах чиглэлээр авсан арга хэмжээгээ дүгнэдэг ч чухам аль компани, аль санхүүгийн зуучлагч хууль зөрчиж хариуцлага тооцуулсан тухай тодорхой мэдээлэл өгдөггүй. Эцсийн бүлэгт компанийн засаглалын үндсэн зарчим, хувьцаа эзэмшигчдийн үндсэн эрх, тухайлбал хувьцаа эзэмшигчдийн хурлыг жил бүр зарлан хуралдуулах, жилийн санхүүгийн тайлан тэнцэлд аудит хийлгэх зэрэг олон тооны шаардлагууд бодит байдал дээр мөрдөгдөхгүй байгаа учраас хэрэгжилт нь хангалттай байна. СЗХ өөрийн зохицуулалтанд байгаа ББСБ-ууд дээр хууль дүрмийн хэрэгжилтийг хангаж чадахгүй байгаа нь үр дүнтэй хариуцлагын тогтолцоо байхгүй байгаатай шууд холбоотой хэмээн зах зээлийн ихэнх оролцогчид үзэж байна. Компаниудын хувьд СЗХ-нд

⁶ FRC Resolution No. 210.

⁷ BoM Regulation No. 594.

⁸ Art. 10 (1) FRC Law.

⁹ Overall, the World Bank's Worldwide Governance Indicators Project ranked Mongolia in the 41st percentile in terms of regulatory quality. See <http://info.worldbank.org/governance/wgi>.

торгууль ногдуулах эрх мэдэл ч байхгүй. СЗХ-ны зохицуулалтанд 400 орчим компани, 137 ББСБ байдаг учраас боловсон хүчин, эх үүсвэр дутагдаж байна. Нэш жишээ хэлэхэд СЗХ-нд 3 улсын байцаагч ажиллаж байна.

МБ мөн үр бүтээлгүй зохицуулагч байгууллагад тооцогдож сайн нэр хүндтэй болж чадсан ч хууль дүрмийг сахиулах тал дээр учир дутагдалтай хандсан гэсэн асуудал сүүлийн үед сөхөгдөөд байна. 2008 онд ОУВС, Дэлхийн Банк хамтран Банкны хяналт шалгалтын Базелийн үндсэн зарчмын хэрэгжилтэнд үнэлгээг хийж, банкны хяналт шалгалтын тогтолцоо өнгөрсөн жилүүдэд мэдэгдэхүйц сайжирч өнөөгийн хөгжлийн түвшинд харьцангуй өндрөөр тооцжээ. Эрсдэлд суурилсан хяналт шалгалт явуулахад шаардлагатай мэргэжлийн чадавхи (гэхдээ МБ туршлагатай боловсон хүчнээ өндөр цалинтай хувийн хэвшилд алдаж байгаа тухай гомдол хэлж байсан), хяналтын тогтолцоог ерөнхийд нь бүрдүүлж чадсан байна.¹⁰ МБ мөн нийтлэг жишигт нийцүүлэн УИХ-д үйл ажиллагаа тайлагнаж, хариуцлага хүлээдэг бөгөөд жилийн тайлан гаргахдаа чухам аль банкуудад хариуцлага тооцсон тухай тодорхой мэдээллийг тусгаж өгдөггүй. Нөгөө талаас банкууд сүүлийн үед санхүүгийн хүндрэлд орсон нь банкны хяналт шалгалтыг, нэн ялангуяа банкны түвшин дэх үйл ажиллагааны эрсдэл, засаглалын чиглэлээр бэхжүүлэх хэрэгтэй болохыг харуулж байна.

МХБ 1991 оноос хойш ажиллаж байна. МХБ-ийн ажилтнуудын цалин хувийн хэвшил, төрийн байгууллагын, тэр дундаа МБ, СЗХ-ны ажилтнуудын цалинтай дүйхүүц түвшинд байдаг ч гэсэн удирдах албан тушаалын хүмүүсийг татах, идэвхжүүлэх, тогтвортой ажиллуулж чадаагүй байна. МХБ-тэй холбоотойгоор зах зээлийн оролцогчид янз бүрийн байр суурь илэрхийлж, хувийн өмчит хөрөнгийн биржийг өрсөлдүүлэн байгуулах талаар ч яригдаж байжээ. МХБ нь 100 хувийн төрийн өмчит аж ахуйн нэгж учраас түүний захирлыг ТӨХ-ноос томилдог ч СЗХ-нд албан ёсоор тайлагнаж, хариуцлагын тогтолцоонд хий орон зайг үүсгэж байна. МХБ-ийг хувьчлах талаар яригдаад удаж байна.

Шүүхийн тогтолцоо сүүлийн хэдэн жилд боловсронгуй болсон гэж үздэг. Дэлхийн Банкны Бизнес эрхлэхүй судалгааны “гэрээ хэлцлийн хэрэгжилт” үзүүлэлтээр Монгол Улс 38-р бичигдсэн байна. Нөгөө талаас зарим шүүгчдэд Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуультай холбоотой компанийн нарийн төвөгтэй маргааныг хянан шийдвэрлэх мэдлэг туршлага дутагдаж байна. Шүүх ажиллагаа 6-18 сарын хугацаанд үргэлжлэх талтайгаас гадна үр ашиггүйд тооцогддог. Ц аашилбал, дээд албан тушаалтан эсвэл их хэмжээний мөнгөн дүнтэй хэргийг маргаантай байдлаар шийдвэрлэсэн тохиолдлууд хэд хэд гарсныг зах зээлд оролцогчид тэмдэглэсэн байдаг. Монголын Худалдаа, аж үйлдвэрийн танхим арилжаа, компани, үнэт цаастай холбоотой асуудлаар арбитрагийн шүүхийн үйлчилгээ үзүүлдэг бөгөөд энэ шүүхийн шийдвэр эцсийн гүйцэтгэх шийдвэр болдог.¹¹ Монгол Улс Гадаадын арбитрайн шийдвэрийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх тухай Нью-Йоркийн Конвенцид нэгдэн орсон. Бодит байдал дээр арбитрайн шүүхийг ашигладаг бөгөөд гадаадын (эсвэл дотоодын) арбитрайн шүүхийн ажиллагаанаас гаргасан шийдвэрийг эргэж хяналгүйгээр Монгол Улсын шүүх хэрэгжүүлдэг.

Монгол Улсын Компанийн засаглалын тогтолцооны OECD Зарчмуудыг 1-р бүлгийн заалтуудтай нийцэхгүй байгаа асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Монгол Улс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Үүнд:

¹⁰ IMF Country Report No. 08/300. Mongolia: Financial System Stability Assessment, Sept. 2008.

¹¹ Art 40 (1) and 42 (1) Arbitration Law of 2003.

Богино хугацаанд хүрэх эн тэргүүний зорилтууд

Дунд хугацаанд хүрэх эн тэргүүний зорилтууд

- *Хууль дүрэм сахиулагч бүх байгууллагууд, нэн ялангуяа МБ, СЗХ, МХБ-ийн банк, ББСБ, компаниуд дээрх хэрэгжилтийг хангах арга хэмжээгээ чангатгаж холбогдох хууль дүрмийн хэрэгжилтийг сайжруулах.* Энэ зорилгоор тэдгээрийн хөрөнгө нөөц, хяналт шалгалтын үйл ажиллагаа, тайлан мэдээ, хараат бус бие даасан байдлыг хянан үзэж тавьсан зорилгодоо хүрэх нөхцлийг бүрдүүлэх. Үүнтэй зэрэгцүүлэн СЗХ, МБ УИХ-ын өмнө хууль дүрмийг хэрэгжүүлэх хариуцлага хүлээдэг болох.
- *Сангийн яам, МБ, СЗХ, МХБ зэрэг улсын секторын эрх бүхий гол байгууллагууд болон бусад байгууллагууд компанийн сайн засаглалыг ухуулан сурталчлахад дэмжлэг тусалцаа үзүүлэх.* Үүний тулд үүсэн хөгжиж буй сургалтын байгууллагуудад дэмжлэг үзүүлэх, компанийн засаглалын арга хэмжээ зохион байгуулах буюу оролцох, компанийн засаглалын холбогдолтой мэдээ материал нийтлэх, компанийн сайн засаглалыг бизнесийн байгууллагад бий болгох ач холбогдлыг олон нийтэд хөхиүлэн дэмжих.
- *СЗХ, МХБ биржид бүртгүүлэх шалгуурыг чангатгаж, хууль эрх зүй, зохицуулалтын шаардагыг хангаж ажиллаагүй компаниудыг бүртгэлээс хасах.*
- *Компанийн сайн засаглалын олон улсын жишигт орсон өөрчлөлтүүдийг тусгах үүднээс холбогдох бүх хууль дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулах.* Хууль дүрэм тогтоогч, хэрэгжүүлэгч холбогдох бүхий л байгууллагууд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль эрх зүй, зохицуулалтын тогтолцоонд нэмэлт өөрчлөлт оруулан боловсронгуй болгох, санал дүгнэлт олж авах, шинээр батлагдсан хуулийн зүйл заалтыг тайлбарлах дугуй ширээний арга хэмжээг зохион байгуулах, санал гомдол цуглуулж, дэмжлэг олж авах, санал дүгнэлтийг Интернетээр нийтэд мэдээлэх. Нэн ялангуяа МУКЗД-нд нэмэлт өөрчлөлт оруулж олон нийтээр дахин хэлэлцүүлэх, улсын салбарт сурталчилж, дэмжлэг олж авах.
- *Зохицуулагч болон зохицуулагчтай адилтгах бүхий л байгууллагуудын үйл ажиллагааг илүү тунгалаг болгох,* нэн ялангуяа хууль дүрмийг сахиулах чиглэлээр авсан арга хэмжээг нийтэд мэдээлэх. МХБ МУКЗД-ийг сайн дурын үндсэн дээр дагаж мөрдөх замаар өөрөө үлгэр дуурайл болох.

Зөвлөмжийн дэлгэрэнгүйг энэхүү тайлангийн “Бодлогын зөвлөмж ба үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 4-р хэсгээс харна уу.

CHAPTER II

The Rights of Shareholders and Key Ownership Functions

Хэрэгжилтийн байдалд хийсэн шинжилгээ

Зарчим II.А: Компанийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалсан байна. Хэрэгжсэн байдал: Хэсэгчлэн хэрэгжсэн

Монгол Улс OECD Зарчмуудын 2-р бүлгийг хэсэгчлэн хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

Хувьцаа эзэмшигчдийн хэд хэдэн үндсэн эрхийг хуулийн хүрээнд тусгажээ. Тухайлбал, хувьцаа эзэмшигчдийн хуралт оролцож, ТУЗ-ийн гишүүдийг сонгох. Гэхдээ бодит байдал дээр эдгээр эрхүүдийг тогтмол мөрдөхгүй байна. Хүснэгт 1-д харуулсанчлан хувьцаа эзэмшигчдийн үндсэн эрх хуулиар хангагдсан байна.


Хүснэгт 1: Зарчим II. А-ийн дагуу хувьцаа эзэмшигчдийн үндсэн эрхийн хууль зүйн шинжилгээ		
1. Өмчлөлийг бүртгүүлэхэд аюулгүй байх	☐	Компанийн тухай хуулийн 46-р зүйл: Компаниуд хувьцаа эзэмшигчдийн жагсаалттай байх, харин Үнэт цаасны төлбөр тооцоо, нэгдсэн хадгаламжийн төв дээр нэгдсэн бүртгэл байх бөгөөд хувьцаа эзэмшигчид энэ хоёр мэдээллийн санг шалгах боломжтой байна.
	☐	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 25.3-р заалт: Үнэт цаасны төлбөр тооцоо, нэгдсэн хадгаламжийн төв үнэт цаасны бүрэн бүтэн байдлыг хамгаалж, хангах үүргээ биелүүлээгүй бол хариуцлага хүлээнэ.
	☐	Үнэт цаасны төлбөр тооцоо, нэгдсэн хадгаламжийн төвийн төлбөр тооцооны сүлжээ өргөн хүрээтэй бөгөөд найдвартайд тооцогддог.
2. Хувьцааг дамжуулах буюу шилжүүлэх	☐	Компанийн тухай хуулийн 4.1-р заалтын дагуу хувьцааг чөлөөтэй шилжүүлэ болно. ¹²
	☐	МХБ дээр бүртгэлтэй бүхий л үнэт цаас биет бус хэлбэртэй бөгөөд Үнэт цаасны төлбөр тооцоо, нэгдсэн хадгаламжийн төвд хадгалагдана. Үнэт цаасны төлбөр тооцоо, нэгдсэн хадгаламжийн төвийн эх үүсвэр, боловсон хүчин зохих шаардлагад нийцэж байгаа бөгөөд уг төв хараат бус бие даасан байж чадаж байна. Төлбөр тооцоог нэг өдөрт багтаан DVP -р хийж байна.
3. Мэдээ мэдээллийн эрх	☐	Компанийн тухай хуулийн 96-р зүйлийн дагуу хувьцаа эзэмшигчид чухал ач холбогдолтой мэдээ мэдээллийг авах эрхтэй.
4. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх	☐	Компанийн тухай хуулийн 35.1.1-р заалт: Энгийн хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхтэй. Процедурын шинжтэй механизмын улмаас компаниуд хувьцаа эзэмшигчдийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөхөд саад тотгор болж чадахгүй.
5. ТУЗ-ийн гишүүдийг сонгох/татах	☐	Компанийн тухай хуулийн 63.1.7, 77.1, 77.4-р заалтуудын дагуу хувьцаа эзэмшигчид хуримтлуулах аргаар санал өгч, ТУЗ-ийн гишүүдийг томилох (татах)

¹² Компанийн тухай хуулийн 57.3-р заалтанд онцгой тохиолдлыг тусгасан байдаг: хувьцаа эзэмшигчдийн хурлын олонхийн шийдвэрээр хяналтын багцыг худалдах саналыг цуцалж болно.

		боломжтой.
6. Компанийн ашгаас хувь хүртэх	☒	Компанийн тухай хуулийн 47.3-р заалт: Нэг ангилалд хамаарах хувьцаа эзэмшигчид ашиг хуваарилах асуудал дээр адил тэгш тооцогдох боловч ногдол ашгийг хувьцаа эзэмшигчид биш ТУЗ баталж байна.

Хувьцаа эзэмшигчдийн эдгээр үндсэн эрхийг хуулинд тогтоож өгсөн хэдий ч компаниуд нийтээрээ хуулийг дагаж мөрдөхгүй байна. Тухайлбал: (1) 2007 онд компаниудын дөнгөж 7 хувь нь нийтдээ 7.4 тэрбум буюу 5.2 сая ам. долларын ногдол ашиг хуваарилснаа зарлажээ. Мөн түүнчлэн, зарим компаниуд зөвхөн томоохон хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг хуваарилж, жижиг хувьцаа эзэмшигчдийг хамруулдаггүй тухай зах зээлд оролцогчид мэдэгдэж байна (бодит мэдээгээр харуулбал: Үнэт цаасны төлбөр тооцоо, нэгдсэн хадгаламжийн төвөөр дамжуулан ногдол ашгаа хуваарилсан 13 компанийн 46,500 хувьцаа эзэмшигчид нийтдээ 6.3 тэрбум төгрөгийн ногдол ашиг авах ёстой байсан ч эцсийн дүндээ 800 хувьцаа эзэмшигчид 5.8 тэрбум төгрөгийн ногдол ашиг авчээ). Цаашилбал, бодит байдал дээр брокерын пүүсүүд ногдол ашгийг жижиг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ажилд туслалцаа дэмжлэг үзүүлдэггүй байна; (2) 2000-2007 онуудын хооронд компаниудын талаас илүү хувь нь хувьцаа эзэмшигчдийн хурлаас зарлан хуралдуулаагүй байна (Зураг 2); (3) санхүүгийн тайлан тэнцлээ хувьцаа эзэмшигчиддээ танилцуулдаг компани цөөхөн байна.¹³

Figure 2: Companies conducting a GMS and paying dividends



Зарчим II.В: Хувьцаа эзэмшигчид компанийг үндсээр нь өөрчлөх асуудлаар шийдвэр гаргахад оролцох эрхтэй бөгөөд уг шийдвэрийн талаар хангалттай мэдээлэл авсан байна.
Хэрэгжсэн байдал:
Хэсэгчлэн хэрэгжсэн

Хувьцаа эзэмшигчид нь компанийн дараах үндсэн өөрчлөлтийн талаар шийдвэр гаргахад оролцох, хангалттай мэдээлэл авах, батлах хууль ёсны эрхтэй байна. Үүнд: (1) үүсгэн байгуулах тухай гэрээ, түүнтэй адилтгах түвшний баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах (Компанийн тухай хуулийн 63.1.1-р заалт); (2) жирийн бус ажил гүйлгээ хийх, тэр дундаа нийлэх тухай гэрээ байгуулах (Компанийн тухай хуулийн 63.1-р заалт) болон ашиг сонирхлын зөрчилтэй ажил гүйлгээ хийх (Компанийн тухай хуулийн 84.1, 89.4.2-р заалтууд); (3) давуу эрхийг өнжих (Компанийн тухай хуулийн 39.6-р заалт). Гэхдээ зөвхөн холбогдох этгээдийн жирийн бус ажил гүйлгээг хувьцаа эзэмшигчдийн 2/3-ын саналаар батална. Мөн түүнчлэн, компанийн дүрмийн санг нэмэгдүүлэх, хувьцаа шинээр гаргах асуудлыг үүсгэн байгуулах гэрээнд өөрөөр заагаагүй бол хувьцаа эзэмшигчид биш ТУЗ-ийн шийдвэрээр баталж (Компанийн тухай хуулийн 43.1, 76.1-р заалт) байгаа нь хувьцаа

¹³ СЗХ-ны 2007 оны жилийн тайлан.

Зарчим II.C: Shareholders should have the opportunity to participate effectively and vote in the GSM.

Status: Хэсэгчлэн

Зарчим II.D: Эзэмшиж байгаа хувь хэмжээнээс үл хамаарсан хяналт тавих нөхцлийг хувьцаа эзэмшигчдэд олгосон өөрийн хөрөнгийн бүтцийг нээлттэй болгосон байна.

Хэрэгжсэн байдал:
Хэсэгчлэн хэрэгжсэн

Зарчим II.E: Засаглалын хяналтын зах үр ашигтай, тунгалаг байдлаар ажиллах нөхцөл боломж бүрдсэн байна.

Хэрэгжсэн байдал: Үндсэндээ хэрэгжсэн

эзэмшигчдийг оролцуулахаар заасан нийтлэг жишигт нийцэхгүй байна.¹⁴

Компаниуд хувьцаа эзэмшигчдийн хурал болох өдөр, байриил, хурлаар хэлэлцэх асуудал, шийдвэрлэх асуудлуудын талаарх мэдээллийг хангалттай хэмжээгээр хугацаа алдалгүй гаргаж өгөх үүрэгтэй. Хувьцаа эзэмшигчдийн хурал болохоос 30 хоногийн өмнө мэдэгдэл өгч, хувьцаа эзэмшигчдэд хангалттай хэмжээний мэдээ материалыг, тэр дундаа жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцэл (Компанийн тухай хуулийн 66.4-р заалт), ТУЗ-д нэр дэвшсэн хүмүүсийн талаарх мэдээллийг (Компанийн тухай хуулийн 66.4.4-р заалт) гаргаж өгөх үүрэгтэй байна. Мөн түүнчлэн, компанийн нийт хувьцааны 10-аас багагүй хувийг эзэмшигч этгээд хувьцаа эзэмшигчдийн жагсаалт, тэр дундаа нэр, хаяг, бусад хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааны тоог гаргуулж авах боломжтой.

Хувьцаа эзэмшигчдын хурлын үеэр хувьцаа эзэмшигчид ТУЗ-өөс асуулт асуух албан ёсны бололцоо байдаггүй ч нөгөө талаас, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, санал өгөх эрхтэй. Компанийн нийт хувьцааны 5 хувийг эзэмшигч этгээд нийтлэг жишгийн дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтанд санал оруулж болохоос гадна хувьцаа эзэмшигчдийн хурал болохоос 45 хоногийн өмнө ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлж болно (Компанийн тухай хуулийн 67.1-р заалт). Хувьцаа эзэмшигчид саналаа биеэр буюу албан ёсны эрх мэдэл бүхий итгэмжлэхээр, харин ээлжит бус хурлын хувьд шуудангаар өгч болно. Хувьцаа эзэмшигчид ТУЗ-өөс асуулт асуух бололцоо муу бөгөөд ТУЗ-ийн гишүүд асуултанд нь хариулах үүрэг, шаардлага байхгүй.

Хувьцаа эзэмшигчид компанийн засаглалын гол шийдвэр, нэн ялангуяа ТУЗ-ийн гишүүдийн цалин харамж (Компанийн тухай хуулийн 66.5.14-р заалт)-ийн асуудлаар шийдвэр **гаргахад оролцох боломжтой.** Гэхдээ энэ эрх нь ТУЗ-ийн зөвхөн бие даасан гишүүнд эсвэл бусад үндсэн гишүүдэд хамаарах эсэх нь тодорхой биш байна.

Компанийн засаглалын тогтолцооны хүрээнд компаниуд өөрийн хөрөнгийн бүтцээ нийтэд танилцуулах үүрэг хүлээдэггүй. Компанийн нийт хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээд хувьцаа эзэмшигч тус бүрийн эзэмшиж байгаа хувьцааны тоог компаниас гаргуулж авах боломжтой (Компанийн тухай хуулийн 96.3-р заалт). Мөн түүнчлэн, хувьцаа эзэмшигчийн ганцаараа буюу хамтран эзэмшиж буй хувь компанийн нийт хувьцааны 5-аас их (таван хувийн интервалтайгаар) буюу 1/3-д хүрсэн нөхцөлд СЗХ-нд мэдэгдэх үүрэгтэй. Харин СЗХ нь таваас дээш хувийг эзэмшиж байгаа этгээдийн талаарх мэдээллийг түгээх үүрэгтэй (СЗХ-ны 206-р тогтоолын Хавсралт 2-ын МС-6-1) ч бодит байдал дээр энэ үүргээ биелүүлэхгүй байна. МУКЗД-ийн дагуу компанийн нийт хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигч этгээдийн нэрийг нийтэд мэдээлвэл зүйтэйд тооцдог (МУКЗД-ийн 5.6-р заалт). Компаниуд групп компанийн бүтэц, хувьцаа эзэмшигчдийн хооронд байгуулсан гэрээ, эсвэл санал өгөх тусгай эрхийн талаарх мэдээллийг нийтэд танилцуулах үүрэг, шаардлага байхгүй. Бодит байдал дээр өмчлөлийн асуудал далд байдаг бөгөөд МБ, СЗХ хүртэл банк, компанийн ашиг хүртэгч өмчлөгч нь чухам хэн болохыг мэддэггүй.

Компанийг хяналтандаа оруулах үйл явцыг зохицуулдаг хууль эрх зүйн журам заавар нь шударга бөгөөд тунгалаг байна. Компанийн нийт хувьцааны 5-аас их хувийг (цаашид хувьцааны тоо 5 хувиар нэмэгдэх тутамд) худалдан авч буй тухайн хувь хүн ажлын 10 хоногт багтаан энэ тухай мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд бус харин СЗХ-нд мэдээлэх үүрэгтэй (Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12-р зүйл). Хувьцаа эзэмшигч дангаараа буюу бусадтай хамтран компанийн нийт хувьцааны 1/3 буюу түүнээс их хувийг худалдан авсан тохиолдолд хуулийн дагуу давуу эрхтэй

¹⁴ If the board does not unanimously adopt the resolution to conclude a major transaction, including the issuance of new shares equal to or more than 25 percent of outstanding shares, then the resolution shall be submitted for shareholders approval (Art. 85.1 CL).

Зарчим II.F: Бүх төрлийн хувьцаа эзэмшигчид, тэр дундаа зохион байгуулалтанд орсон байгууллагын хувьцаа

болдог. Энэ нөхцөлд хувьцааны үнэ өмнөх 6 сарын зах зээлийн үнийн жигнэсэн дундажаас багагүй байхаар заажээ. Хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн 2/3-ын саналаар энэхүү давуу эрхийг эдлүүлэхгүй байх боломжтой. Монгол Улсад хяналтаа багцаа алдахаас хамгаалсан хэрэгслүүд ашиглагддаггүй байна. Х яналт солигдох үед анхаарал, үнэн байдлын үүргийг хэрэгжүүлэхийг хууль эрх зүй, зохицуулалтын хүрээнд шаарддаггүй хэдий ч компанийн ТУЗ-ийн гишүүд, ажилтнуудыг сайн санаа, компанийн эрх ашгийн үүднээс ажиллахаар заажээ (Компанийн тухай хуулийн 81.2-р заалт). Эцэст нь компаниудыг хөрөнгийн биржийн бүртгэлээс хасах зорилгоор худалдах, шахах эрхийг хуулийн хүрээнд тогтоож өгөөгүй байна.¹⁵

Зохион байгуулалттай хөрөнгө оруулагч нарын өмчлөлийн эрхийн талаар хууль эрх зүй, зохицуулалтын хүрээнд тусгагдсан зүйл байдаггүй. Тодруулбал, зохион байгуулалттай хөрөнгө оруулагчид санал өгөх, санал өгөх бодлого, санал өгсөн байдлаа мэдээлэх үүрэг хүлээгээгүй. Х өрөнгө оруулсан компанийнхаа засаглалыг бэхжүүлэх чиглэлээр ажиллах талаар мөн ямар нэгэн үүрэг хүлээдэггүй байна. Эцэст нь, зохион байгуулалттай хөрөнгө оруулагчид ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэх бодлого боловсруулж, нийтэд мэдээлэх үүрэг шаардлага хүлээдэггүй. Д ээр дурьдсанчлан зохион байгуулалттай байгууллагын хөрөнгө оруулагчид Монгол Улсад ямар нэгэн үүрэг гүйцэтгэдэггүй болно.

Компанийн засаглалын тогтолцооны хүрээнд хувьцаа эзэмшигчид өөр хоорондр зөвлөлдөхийг шууд зөвшөөрөөгүй, мөн хориглоогүй байна. Х ууль эрх зүй, зохицуулалтын орчинд энэ асуудлын талаар ямар нэгэн зүйл тусгагдаагүй. Гэхдэ Компанийн тухай хуулинд зааснаар компанийн нийт хувьцааны 10-аас багагүй хувийг эзэмшигч этгээд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдын жагсаалттай танилцах эрхтэй байдаг нь хувьцаа эзэмшигчдийг өөр хоорондоо зохицуулалт хийх боломжийг олгож байна гэж үзэж болно.

Зарчим II.G: Хувьцаа эзэмшигчдийн үндсэн эрхтэй холбоотой асуудлаар тэд бусадтайгаа харилцан зөвлөлдөх эрхтэй байна. **Хэрэгжсэн байдал:** Үндсэндээ хэрэгжсэн

Зөвлөмж

Монгол Улсын Компанийн засаглалын тогтолцооны OECD Зарчмуудыг 2-р бүлгийн заалтуудтай нийцэхгүй байгаа асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Монгол Улс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Үүнд:

- **Компанийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж,** ногдол ашгийг ТУЗ биш хувьцаа эзэмшигчид баталдаг болгох. СЗХ нөгөө талаас брокерууд хуулийн дагуу ногдол ашгийг жижиг хувьцаа эзэмшигчдэд хуваарилж байх нөхцлийг хангах.
- **Компанийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах.** Үүнд: (1) компанийг үүсгэн байгуулах гэрээ, давуу эрхийг эдлүүлэхгүй байх зэрэг компанийн холбогдолтой томоохон шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн 2/3-ын саналаар баталдаг байх; (2) компанийн дүрмийн санг нэмэгдүүлэх, хувьцаа шинээр гаргах шийдвэрийг ТУЗ-ын санал дээр үндэслэн хувьцаа эзэмшигчид гаргадаг байх; (3) компаниудыг групп компанийн өөрийн хөрөнгийн бүтэц, хувьцаа эзэмшигчдийн хооронд байгуулсан гэрээ, саналын тусгай эрх зэргийг нийтэд мэдээлэх үүрэгтэй болгох.

Богино хугацаанд хүрэх эн тэргүүний зорилтууд

Дунд хугацаанд хүрэх эн тэргүүний зорилтууд

¹⁵ The “squeeze-out” right is the right of a majority shareholder to compel minority shareholders to sell their shares to him, with appropriate safeguards to protect minority shareholders and ensure for a fair valuation of shares. The squeeze-out right is the mirror image of the “sell-out” right, which allows a minority shareholder to compel the majority shareholder to purchase his shares.

CHAPTER III

The Equitable Treatment of Shareholders

Хэрэгжилтийн байдалд хийсэн шинжилгээ

Зарчим III.A: Нэг ангилалд хамаарах хувьцаа эзэмшигчдэд адил тэгш хандана.
Хэрэгжсэн байдал:
Хэсэгчлэн хэрэгжсэн

Монгол Улс OECD Зарчмуудын 3-р бүлгийг хэсэгчлэн хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

Хувьцааны ангиллуудад адил тэгш, шударга хандах, эрхийг нь нийтэд ил тод болгох асуудал хуулийн дагуу хангагдсан. Монгол Улсын хууль эрх зүйн орчин OECD Зарчмуудад тодорхойлсон нийлэг жишгээс давж, нэг хувьцаа нэг саналын эрхтэй байхаар заасан. Гэхдээ хуримтлуулсан санал хураалт нь онцгой тохиолдол болдог (Компанийн тухай хуулийн 64.2-р заалт). Нөгөөс талаас, хувьцааны янз бүрийн төрөл, ангиллын саналын эрхийг өөрчлөх саналыг хувьцаа эзэмшигчдээр батлуулах шаардлагагүй байдаг. Цаашилбал, компаниуд өөрийн хувьцааны төрөл, ангиллын талаарх мэдээллийг нийтэд мэдээлэх үүрэг, шаардлага байхгүй байна.

Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хяналт багц эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн зүгээс (үзүүлж болох) дарамт шахалтаас тодорхой хэмжээгээр хамгаалсан. Компанийн засаглалын тогтолцооны хүрээнд дараах нөхцлүүд бүрдсэн байна. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах *шийдвэр гаргахаас өмнөх* механизмууд, тухайлбал: (1) компанийг үүсгэн байгуулах тухай тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах, өөр компанитай нийлэх буюу худалдах, ашиг сонирхлын зөрчилтэй ажил гүйлгээг зөвшөөрөхийн тулд хувьцаа эзэмшигчдийн 2/3-ын санал (Компанийн тухай хуулийн 64.5-р заалт); (2) нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг эзэмшигч этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарлан хуралдуулж, ээлжит бус аудит хийлгүүлэх боломж (Компанийн тухай хуулийн 62.2, 91.2-р заалтууд); (3) компанийн бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх, онцгой ажил гүйлгээг зөвшөөрөх, компанийн дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр болсон санал хураалтад эсрэг саналтай байсан буюу санал хураалтанд оролцоогүй хувьцаа эзэмшигчид санала татах эрх.
- Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах *шийдвэр гаргасны дараах* арга хэмжээнүүд, тухайлбал: (1) нийт хувьцааны нэг буюу түүнээс хувийг эзэмшигч этгээд компанид учирсан аливаа хохирлыг барагдуулах нэхэмжлэхийг компанийн ТУЗ-ийн гишүүд, ажилтнуудын эсрэг шүүхэд гаргах боломж (Компанийн тухай хуулийн 83.1, 87.2, 90.4-р заалтууд). Үүнтэй холбогдуулан нэг зүйлийг дурьдахад энэхүү заалт нь нэг хувьцаа эзэмшигчид эсвэл хэсэг хувьцаа эзэмшигчдэд хамаарах эсэхийг хуулинд тодорхой зааж өгөөгүй байна. Бодит байдал дээр ТУЗ-ийн гишүүдийн эсрэг шүүхэд нэхэмжлэх гаргасан хувьцаа эзэмшигчид цөөхөн байдаг.

Ашиг хүртэгч өмчлөгч өөрийн асран хамгаалагчид саналаа хэрхэн өгөх талаар чиглэл өгч болох эсэх, мөн асран хамгаалагчид санал өгөх бодлогоо тодорхойлох үүрэг, шаардлагатай эсэхийг компанийн засаглалын тогтолцоонд тусгаагүй

байна. Монгол Улсын хувьд асран хамгаалагчид ямар нэгэн үүрэг роль гүйцэтгэдэггүй.

Хил дамнаж санал өгөхөд саад тотгор байхгүй. Гадаадын иргэд эрхээ эдлэж болохыг хуулинд тодорхой заажээ (Компанийн тухай хуулийн 12.2-р заалт). Цаашилбал 30 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэж, саналаа шуудангаар өгөх боломж олгосноор гадаадын хөрөнгө оруулагчид саналын эрхээ бүрэн эдлэх нөхцлөөр хангагдаж байна. Газрын тос, ашигт малтмал зэрэг стратегийн салбарт оруулж буй гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэлт журмаар зохицуулж байна. Бодит байдал дээр гадаадын хөрөнгө оруулагчид хяналт шалгалт, тусгай зөвшөөрөл олгох үйл явц учир дутагдалтай байгаа талаар мэдээлдэг.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр хувьцаа эзэмшигчдэд адил тэгш хандах нөхцөл бүрдсэн. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулахдаа санал өгөх нөхцлийг бүрдүүлэх үүднээс компаниуд хувьцаа эзэмшигчдийн олонх төвлөрсөн, тэдэнд хамгийн бага зардал болох газрыг сонгох үүрэгтэй байдаг (Компанийн тухай хуулийн 3.15-р заалт). Санал хураалт нууцаар явагдах бөгөөд хувьцаа эзэмшигчид санал тоолох хараат бус бие даасан комисс байгуулахаар шийдвэрлэж болно (Компанийн тухай хуулийн 681-р зүйл, 68.2-р заалт). Эцэст нь, санал хураалтын дүнг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр буюу хувьцаа эзэмшигчдэд зориулсан тусгай тайланд зарлах ёстой (Компанийн тухай хуулийн 74.4-р заалт).

Компанийн дотоод мэдээллийг ашиглаж биржийн арилжаанд оролцохыг хуулиар хориглосон байдаг ч хуулийг хэрэгжүүлэх ажил хангалтгүй байна. Компанийн дотоод мэдээллийг ашиглаж биржийн арилжаанд зохистой бусаар оролцож, зах зээлийн нөхцлийг гуйвуулахыг хуулиар хориглож (Үнэт цаасны тухай хуулийн 17.2-р заалт), “компанийн дотоод мэдээллийг ашиглаж биржийн арилжаанд оролцох”, “компанийн дотоод мэдээллийг эзэмшигч”-ийг хуулинд хангалттай өргөн хүрээнд тодорхойлж (Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3.15, 17.1-р заалтууд) компанийн дотоод мэдээллийг ашиглаж биржийн арилжаанд оролцох ихэнх тохиолдлуудыг хамарч чадсан байна. Компанийн дотоод мэдээллийг эзэмшигч нь компанийн эд хөрөнгийг зүй бусаар буюу хувьдаа, эсвэл албан тушаалаа урвуулан ашигласан нөхцөлд торгууль төлөх буюу 10 хүртэл жилийн хорих ялаар шийтгүүлж, үндсэндээ ТУЗ-ийн гишүүн, ажилтан болох эрхгүй болдог (Эрүүгийн хуулийн 150, 265-р зүйлүүд). Нөгөө талаас, ТУЗ-ийн гишүүд, ажилтнууд тухайн компанийн үнэт цаасны арилжаанд оролцохыг хориглосон, мөн энэ мэдээллийг хугацаа алдалгүй хувьцаа эзэмшигчид, зах зээлд нээлттэй болгох хаалттай хугацаа байхгүй байна. Мөн түүнчлэн, МХБ-ээс арилжааны мэдээнд тогтмол цуглуулж, дүн шинжилгээ хийн дотоод мэдээлэл ашиглаж арилжаанд оролцож байгаа эсэхийг оновчтой тогтоох байр суурьтай байдаг боловч дотоод мэдээлэл ашиглаж арилжаанд оролцогчдын эсрэг өнөөг болтол цөөн арга хэмжээ авсан байна. Зах зээлийн хэд хэдэн оролцогч дотоод мэдээлэл ашиглаж арилжаанд оролцох асуудал шийдвэрлэгдэхгүй удаж байгаа асуудал гэж тэмдэглэсэн.

Зарчим III.B:

Байгууллагын дотоод мэдээллийг ашиглаж биржийн арилжаанд оролцох, компанид эзлэж буй байр сууриа урвуулан ашиглахыг хориглоно.

Хэрэгжсэн байдал:

Хэрэгжсэн хэрэгжсэн

Зарчим III.C: ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын гол ажилтнууд аливаа ажил гүйлгээнд материаллаг ашиг сонирхол байгаа эсэхээ ТУЗ-д мэдээлсэн байна.
Хэрэгжсэн байдал:
Хэсэгчлэн хэрэгжсэн

Ашиг сонирхлын зөрчил, холбогдох этгээдийн ажил гүйлгээний асуудал хуулийн хүрээнд хангалттай хэмжээнд зохицуулагдсан хэдий ч бодит байдал дээр асуудал дагуулж, зохицуулагч байгууллагуудын зүгээс хэрэгжилтийг нь зохих хэмжээнд хангаж чадахгүй байна. ТУЗ-ийн гишүүд, гол захирлууд компанийн эрх ашигт нөлөөлж буй материаллаг ашиг сонирхолтой холбоотой мэдээ мэдээллийг ТУЗ болон хөндлөнгийн аудиторт гаргаж өгсөн байх үүрэгтэй (Компанийн тухай хуулийн 88.1.3-р заалт). Цаашилбал, Компанийн тухай хууль (86.1-р заалт) болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулинд (НББОУСТ-ын 24.1-р заалт) холбогдох этгээдийн зохих байдлаар тодорхойлжээ. Үүнтэй холбогдуулан нэг зүйлийг дурьдахад ТУЗ нь ашиг сонирхлын зөрчилтэй ажил гүйлгээг хянан хэлэлцэж, батлах үүрэгтэй байдаг (Компанийн тухай хуулийн 76.1.17-р заалт). Мөн түүнчлэн ТУЗ-ийн ашиг сонирхлын зөрчилтэй гишүүд ашиг сонирхол нь зөрчигдсэн тохиолдолд санал өгөхөөс татгалзаж болно (Компанийн тухай хуулийн 76.2, 79.5-р заалтууд). Цаашилбал компанийн нийт хөрөнгийн 2 хувиас давсан хэмжээний дүнтэй зэрэг ашиг сонирхлын зөрчил бүхий ажил гүйлгээг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар батлах учиртай (Компанийн тухай хуулийн 89.4-р заалт). Санхүүгийн тайлагналын шалгуурын хувьд холбогдох этгээдийн ажил гүйлгээний талаар мэдээлэхийг шаардсан байдаг (НББОУС-ийн 24.1-р заалт). Хууль эрх зүй, зохицуулалтын орчны хувьд нийтлэг жишигт нийцсэн хэдий ч зах зээлд оролцогчдын ихэнх нь ашиг сонирхлын зөрчилтэй ажил гүйлгээнүүд хийгдэж, компанийн дотоод мэдээлэл эзэмшигчид компанийн эд хөрөнгийн хувийн ашиг сонирхлын үүднээс завшиж байгаа нь томоохон асуудал гэж тэмдэглэжээ. СЗХ-ны дээр дурьдсан тайланд ийм зөрчлийн талаар мөн тусгагдсан. Зохицуулагч байгууллагууд хүчин төгөлдөр хууль тогтоомжийг хэрэгжүүлж, ашиг сонирхлын зөрчилтэй ажил гүйлгээ хийж зөрчил гаргасан этгээдэд хариуцлагын арга хэмжээ авч чадахгүй байна.

Зөвлөмж

Богино хугацаанд хүрэх

Дунд хугацаанд хүрэх эн тэргүүний зорилтууд

Монгол Улсын Компанийн засаглалын тогтолцооны OECD Зарчмуудыг 3-р бүлгийн заалтуудтай нийцэхгүй байгаа асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Монгол Улс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Үүнд:

- *ТУЗ-ийн гишүүд, ажилтнууд* өөрийн компанийн үнэт цаасны *арилжаанд оролцохыг хориглосон хаалттай хугацааг тогтоох*; ТУЗ-ийн гишүүд компанийн үнэт цаасны арилжаанд оролцсон байдлыг хувьцаа эзэмшигчид, бусад оролцогч талуудад цаг алдалгүй нээлттэй мэдээлэх.
- *СЗХ нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг хатуу чанд мөрдүүлж* холбогдох этгээдийн ажил гүйлгээ хийх, дотоод мэдээлэл ашиглаж биржийн арилжаанд оролцохоос сэргийлэх.
- *Компанийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж*, дараах шаардлагуудыг тусгах. Үүнд: (1) хувьцааны төрөл, ангиллын саналын эрхийг өөрчлөх саналыг хувьцаа эзэмшигчдээр хэлэлцүүлэн батлуулах; (2) компаниуд хувьцааны төрөл, ангиллын талаарх мэдээллийг нийтэд нээлттэй мэдээлэх.

Зөвлөмжийн дэлгэрэнгүйг энэхүү тайлангийн “Бодлогын зөвлөмж ба үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 4-р хэсгээс харна уу.

CHAPTER IV

The Role of Stakeholders in Corporate Governance

хийсэн шинжилгээ

Зарчим IV.A: Хууль тогтоомж буюу харилцан тохиролцсон гэрээний дагуу тогтоосон эрхийг хүндэтгэн эдлүүлнэ.

Хэрэгжсэн байдал:
Хэсэгчлэн хэрэгжсэн

Зарчим IV.B: Сонирхлын бүлгүүдийн ашиг сонирхлыг хуулиар хамгаалсан нөхцөлд зөрчигдсэн эрхийнхээ төлөө нөхөн төлбөр авдаг байх ёстой.

Хэрэгжсэн байдал:

Зарчим IV.C: Ажилтны оролцоог хангах ажлын гүйцэтгэлийг нэмэгдүүлэх механизмтай байж болно.

Хэрэгжсэн байдал:
Хэсэгчлэн хэрэгжсэн

Зарчим IV.D: Хуульд заасны дагуу оролцогч талууд холбогдох найдвартай мэдээ мэдээллийг хангалттай хэмжээгээр хугацаанд нь авах боломжтой байна.

Хэрэгжсэн байдал:
Хэрэгжээгүй

Тухайлбал:

Компанийн засаглалын тогтолцооны хүрээнд оролцогч талуудын хуулийн дагуу олгогдсон эрх хэрэгжих нөхцөл бүрдсэн. Тухайлбал, (1) *ажилчид* эрүүл мэнд, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд ажиллах (Компанийн тухай хуулийн 83.1-р заалт), бусад ажилчидтай эвлэлдэн нэгдэх (Хөдөлмөрийн тухай хуулийн 6.1-р заалт), адил тэгш харилцаанд оролцох (Хөдөлмөрийн тухай хуулийн 7.2-р заалт) эрхтэй; (2) *зээлдүүлэгчид* ч мөн тодорхой эрх эдэлнэ, тухайлбал, зах зээлийн үнэлгээний улмаас компанийг төлбөрийн чадваргүй болгосон ажил гүйлгээг буцаах хүсэлтийг шүүхэд гаргах эрх (Компанийн тухай хуулийн 49-р зүйл); (3) *хүрээлэн буй орчинг* хуулийн хамгаалалтанд авч, компаниудаас байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийхийг шаардан (Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3-р зүйл), тэдгээрийн үйл ажиллагаа байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж хувь хүмүүсийн эд хөрөнгө, эрүүл мэндэд учирсан хохирлыг барагдуулах үүрэгтэй (Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4-р зүйл). Бодит байдал дээр оролцогч талуудын эрхийг хүндэтгэн эдлүүлдэг компаниуд ховор байна.

Компанийн засаглалын тогтолцооны хүрээнд оролцогч талуудын эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн хэрэгжилтийг хангах, засаж залруулах арга хэмжээний механизм багтсан байна. Ажил олгогч болон ажилчин, хамт олон хоёрын хооронд үүссэн хөдөлмөрийн маргааныг Хөдөлмөрийн маргааныг хянан шийдвэрлэх хороо (Компанийн тухай хуулийн 116, 125-р зүйл) буюу шүүхээр (CPC-ийн 12-р зүйл). Хуулинд заасны дагуу хуулийн этгээдийн хувьд компани нь үндсэндээ өөрийн оролцогч талуудын эрх ашгийг зөрчсөнийхөө төлөө хариуцлага хүлээх үүрэгтэй. Мөн түүнчлэн компанийн ТУЗ-ийн гишүүд болон ажилтнуудын буруутай үйл ажиллагааны улмаас компанид хохирол учирсан бол хувь хүний хувьд хариуцлага хүлээнэ (Компанийн тухай хуулийн 82.1-р заалт). Дэлхийн Банкны Бизнес эрхлэхүй тайлангийн “гэрээ хэлцлийн хэрэгжилт” үзүүлэлтээр Монгол Улс 38-рт бичигдаж байгаа нь магтууштай хэдий ч шүүх тогтолцооны үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр шийдвэрлэх ёстой асуудлууд цөөнгүй байна.

Компанийн засаглалын тогтолцооны хүрээнд ажилчдын ажлын гүйцэтгэлийг нэмэгдүүлэх механизмтай байхыг зөвшөөрдөг. Компаниуд Ажлын гүйцэтгэлийг нэмэгдүүлэх механизм, нэн ялангуяа ажилчдын хувьцаа, хувьцааны опционы хөтөлбөрийн хувьд хууль эрх зүй, зохицуулалтын тогтолцоонд тусгагдсан зүйл байхгүй байна. Гэхдээ хуулинд дурьдсанаар компаниуд үндсэн цалингаас гадна ажлын гүйцэтгэлээс хамааран ажилчиддаа урамшуулал өгч (Компанийн тухай хуулийн 50-р зүйл), гүйцэтгэх захиралд шагнал амлаж болно.

Компанийн үүсгэн байгуулсан тэтгэврийн сангууд шимтгэл төлөгч бүх хүмүүсийн эрх ашгийн үүднээс эдгээр сангуудыг удирдах үүрэг бүхий хараат бус бие даасан итгэмжлэгдсэн этгээдийн хяналтаас гадуур байна.

Ихэнх оролцогч талуудад компанийн засаглалын үйл явцад чөлөөтэй оролцохын тулд шаардлагатай (найджартай бөгөөд хамгийн сүүлийн үеийн) мэдээ мэдээлэл байдаггүй. Хууль эрх зүй, зохицуулалтын тогтолцооны хүрээнд ажилчид компанийн засаглалын үйл явцад, тухайлбал ТУЗ-өөр дамжуулах буюу ажилчдын зөвлөл байгуулах замаар оролцох эрх байдаггүй. Зээлдүүлэгчид ч мөн ийм эрх нээгдээгүй бөгөөд жил бүр зохион байгуулагддаг авлагатай этгээдүүдийн хурлаар дамжуулах оролцох боломж байхгүй байна. Ер нь энэхүү чухал оролцогч талд хуулийн дагуу хэд хэдэн эрх олгогдсон байдаг. Нөгөө талаас компанийн төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх явцад зээлдүүлэгчдэд холбогдох мэдээ мэдээллийг гаргаж өгөхийг

Зарчим IV.E: Оролцогч талууд хууль бус үйлдлийн талаар чөлөөтэй мэдээлэх боломжтой байх бөгөөд ингэсний төлөө нэр хүндэд халдахыг хорниглоно.
Хэрэгжсэн байдал:
Хэвэгжээгүй

Зарчим IV.F: Компанийн засаглалын тогтолцоог төлбөрийн чадваргүйдлийг зохицуулах үр ашигтай тогтолцоо, мөн зээлдүүлэгчийн эрхийг үр дүнтэй хэрэгжүүлдэг тогтолцоогоор нөхөн баяжуулсан байна.

Зөвлөмж

Богино хугацаанд хүрэх эн тэргүүний зорилтууд

Дунд хугацаанд хүрэх эн тэргүүний зорилтууд

Урт хугацаанд хүрэх эн тэргүүний зорилтууд

хуулинд зааж өгчээ.

Хууль эрх зүй, зохицуулалтын тогтолцооны хүрээнд компаниудад шүгли үлээх бодлоготой байх үүрэг, шаардлага тусгагдаагүй байна. Шүгли үлээх бодлогын хүрээнд ажилчид компанийн буруутай, өөрөөр хэлбэл хууль бус буюу ёс зүйгүй үйлдэл, үйл ажиллагааны талаар мэдээлэх боломжтой байдаг. Гэхдээ компанийн дотоодоос эдгээр шүгли үлээгчдээс эргээд өшөө авахаас хамгаалсан бодлого байхгүй байна.

*Төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх үйл явц асар их уддаггүй хэдий ч олон улсын шилдэг туршлагатай харьцуулахад Монгол Улсын Дампуурлын тухай хуулийн “хэрэгжилт муу” байна.*¹⁶ Тодруулбал, төлбөрийн чадваргүйдлийн тогтолцооны хүрээнд янз бүрийн ангиллын зээлдүүлэгчдийн эрхийг тодорхойлж, бүтцийн өөрчлөлтийн шийдвэр гаргахад зээлдүүлэгчид чухал үүрэг гүйцэтгэх боломжоор үндсэндээ хангагдсан боловч бүтцийн өөрчлөлт хийх, татан буулгах албан ёсны үйл явцад тавих хууль эрх зүй, зохицуулалтын шаардлагууд нь их өртөг зардал, цаг хугацаа шаардаж, зээлдүүлэгчдийн хувьд үр ашиг муутай байдаг байна. Дэлхийн Банкны Бизнес эрхлэхүй тайлангийн “бизнесийн үйл ажиллагааг хаах” үзүүлэлтээр Монгол Улс 2009 онд 108-р дугаарт бичигдсэн нь энэхүү дутагдлын илрэл болж байна.

Монгол Улсын Компанийн засаглалын тогтолцооны OECD Зарчмуудыг 4-р бүлгийн заалтуудтай нийцэхгүй байгаа асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Монгол Улс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Үүнд:

- *Шүгли үлээх бодлогыг компаниудад хэрэгжүүлэхийг хууль эрх зүй, зохицуулалтын тогтолцооны хүрээнд үүрэг болгох буюу МУКЗД-ээр дэмжих.* Ингэснээр ажилчид компанийн буруутай, өөрөөр хэлбэл хууль бус буюу ёс зүйгүй үйлдэл, үйл ажиллагааны талаар мэдээлэх боломжтой болно. Цаашилбал, шүгли үлээгчид компанийн дотоодоос гарч болох өшөө авалтаас хамгаалагдсан байвал зүйтэй.
- *Хууль дүрэм сахиулагч байгууллагууд оролцогч талуудын эрхийг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх,* нэн ялангуяа ажилчид, зээлдүүлэгчид, байгаль орчинд холбогдох эрхүүд.
- *Гол оролцогч талуудыг (найджартай бөгөөд хамгийн сүүлийн үеийн) мэдээ мэдээллээр хангахыг хууль эрх зүй, зохицуулалтын тогтолцооны хүрээнд үүрэг болгох буюу МУКЗД-ээр зөвлөмж болгох,* ингэснээр тэдгээрийн, нэн ялангуяа ажилчид, зээлдүүлэгчдийн компанийн засаглалын үйл явцад оролцох нөхцөл сайжирна.

Монгол Улсын Засгийн газраас Төлбөрийн чадваргүйдэл, зээлдүүлэгчийн эрхийн ROSC үнэлгээг хийлгүүлж, Дэлхийн Банкны Бизнес эрхлэхүй тайлангийн “бизнесийн үйл ажиллагааг хаах” үзүүлэлтээ сайжруулах. 2009 онд энэ үзүүлэлт 108-р дугаарт бичигдсэн байсан

¹⁶ Монгол Улсын худалдаа арилжааны хууль тогтоомж: шилжилтийн явц, ЕСБХБ, 2005.

Зөвлөмжийн дэлгэрэнгүйг энэхүү тайлангийн “Бодлогын зөвлөмж ба үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 4-р хэсгээс харна уу.

CHAPTER V

Disclosure and Transparency

Хэрэгжилтийн байдалд хийсэн шинжилгээ

Зарчим V.A: Мэдээ мэдээллийг нээлттэй болгоход санхүүгийн болон санхүүгийн бус мэдээлэл хамаарах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй. **Хэрэгжсэн байдал:** Хэсэгчлэн хэрэгжсэн

Монгол Улс OECD Зарчмуудын 5-р бүлгийг хэсэгчлэн хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцлээ бүрэн хэмжээгээр нь хувьцаа эзэмшигчдэд нээлттэй танилцуулах үүрэгтэй ч бодит байдал энэ үүргээ биелүүлдэггүй. Хуулинд зааснаар бүх компаниуд СТОУС-ын дагуу аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцэл буюу баланс, орлогын тайлан, мөнгөн урсгалын тайлан, өөрийн хөрөнгийн өөрчлөлтийн тайлан, санхүүгийн тайлан тэнцлийн тайлбарыг бүрэн хэмжээгээр улирал, хагас жил, жилээр (НББ-ийн тухай хуулийн 10.4-р заалт, СЗХ-ны 206-р тушаал) бэлтгэж СЗХ, МХБ-д, харин хувьцаа эзэмшигчдэд зөвхөн жилээр гаргаж үүрэгтэй (Компанийн тухай хуулийн 91.1-р заалт, Үнэт цаасны тухай хуулийн 10.1.3-р заалт, НББ-ийн тухай хуулийн 94.1-р заалт, Аудитын тухай хуулийн 7.1.1-р заалт). СЗХ-ны мэдээгээр 2007 онд компаниудын 78.9 хувь нь санхүүгийн тайлан тэнцлээ эрх бүхий байгууллагуудад гаргаж өгөөгүй бөгөөд нэг ч компани санхүүгийн тайлан тэнцлээ нийтэд мэдээлээгүй байна.¹⁷ 2008 онд хийсэн Нягтлан бодох бүртгэл, аудитын ROSC үнэлгээгээр санхүүгийн тайлагнал чанар, хугацааны хувьд ноцтой алдаатай байгаа нь тогтоогдсон. Зах зээлд оролцогчид Компанийн засаглалын ROSC үнэлгээний ажлын хэсгийн зөвхөн 4-5 компани санхүүгийн тайлан тэнцлээ СТОУС-ын дагуу зохих ёсоор бэлтгэж, нийтэд мэдээлж байна гэсэн дүгнэлтийг баталгаажуулсан. Зах зээлд оролцогчдын дүгнэж байгаагаар нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад мэргэжлийн ур чадвар дутагдаж, СТОУС-ын хэрэгжилт маш муу, мөн хөрөнгө оруулагчид СТОУС-д нийцсэн тайлан мэдээ шаарддаггүй учраас компаниуд СТОУС-д нийцсэн санхүүгийн мэдээ тайлан гаргахгүй байна. Нягтлан бодох бүртгэлийг зөвхөн татварын зориулалтаар хөтөлсөн хэвээр байна. Хуулийн дагуу компаниуд санхүүгийн нэгдсэн тайлан тэнцэл гаргах үүрэгтэй (Компанийн тухай хуулийн 6.2-р заалт) хэдий ч групп эсвэл холдингийн бүтэцтэй цөөн хэдэн компани энэхүү шаардлагыг биелүүлж байна.

Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд удирдлагын хэлэлцүүлэг, шинжилгээг (MD&A) үйл ажиллагааны жилийн тайландаа тусгаж хувьцаа эзэмшигчдэд гаргаж өгөх үүрэгтэй хэдий ч жилийн тайлан гаргадаг компани цөөхөн байна. ТУЗ компанийн жилийн тайлан, тэр дундаа үйл ажиллагааны танилцуулга, үр дүн, өмнөх жилийн үйл ажиллагаа, үр дүнгээс өөрчлөгдсөн байдал, компанийн бүтэц зохион байгуулалтын тайланг хувьцаа эзэмшигчдэд гаргаж өгөх үүрэгтэй (Компанийн тухай хуулийн 94.3-р заалт). Мөн түүнчлэн эрхэм зорилго, стратеги нийтэд танилцуулах учиртай (МУКЗД-ийн 5.7.2-р заалт). Гэтэл зах зээлд оролцогчдын үзэж байгаагаар OECD-ийн гишүүн орны компаниудтай ойролцоо чанарын түвшинд жилийн тайлан, тэр дундаа MD&A бэлтгэж, нийтэд мэдээлдэг 4-5 л компани байна.

Компанийн засаглалын тогтолцооны хүрээнд санхүүгийн бус мэдээ мэдээллийг нийтэд мэдээлэх үүрэг, шаардлага тогтоосон байдаг хэдий ч санхүүгийн бус мэдээллийг нийтэд мэдээлэх явдал ховор буюу огт байхгүй байна. Тухайлбал, компанийн зорилт, ашиг хүртэгч өмчлөгчдийн бүтэц, ТУЗ-ийн үндсэн болон бие даасан гишүүдийн цалин харамжийн бодлого, компанийн засаглалын бодлого зэргийг нийтэд мэдээлэхийг хууль тогтоомж, дүрэм журам, эсвэл МУКЗД-ийн хүрээнд үүрэг болгох буюу дэмжсэн байдаг. Дээр дурьдсанчлан өмчлөлтэй холбоотой баримтуудыг мэдээлдэггүй учраас зохицуулагч нар холбогдох этгээдийн ажил гүйлгээ зэрэг компанийн засаглалын гол заалтуудыг хэрэгжүүлэхдээ асуудалтай тулгардаг.

¹⁷ СЗХ-ны 2007 оны жилийн тайлан, мөн Хорооны даргын хийсэн санал дүгнэлт; <http://siteresources.worldbank.org/INTMONGOLIA/Resources/BayarsaikhanDargaSpeechEng.pdf>

Зарчим V.B: Мэдээ мэдээллийг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн болоод санхүүгийн бус мэдээ мэдээллийг нээлттэй болгох тухай чанарын өндөр түвшний стандартуудад нийцүүлэн бэлтгэж ил тод болгоно.
Хэрэгжсэн байдал:
Үндсэндээ хэрэгжсэн

СТОУС, АОУС-д тус тус үндэслэсэн нягтлан бодох бүртгэл, аудитын стандартуудыг Сангийн яам боловсруулан тайлбар гаргаж, Стандартчилал хэмжилзүйн үндэсний төв (СХЗҮТ) баталдаг. Харин одоогоор Монгол Улсад санхүүгийн бус мэдээллийг нийтэд мэдээлэх стандартыг боловсруулдаг байгууллага нэг ч байхгүй байна. Дээр дурьдсанчлан Монгол Улсын банк, компаниуд (мөн хөрөнгийн биржид бүртгэлтэй ЖДҮ), банк бус санхүүгийн байгууллагууд, төрийн өмчит аж ахуйн нэгжүүд болон олон нийтийн ашиг сонирхол бүхий бусад аж ахуйн нэгжүүд бүгд СТОУС-ыг (мөрдөөгүй ч) бүрэн өөрчлөн тохируулсан. Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартыг боловсруулах, батлах, эргэн хянах процесс тархай байна:

- Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартыг *боловсруулах*—үндсэндээ СТОУС-ыг монгол хэл үрүү орчуулах ажлыг зохион байгуулж, эдгээр стандартыг өөрчлөн тохируулж СТОУС-д суурилсан нягтлан бодох бүртгэл, аудитын үндэсний стандартыг боловсруулах үүргийг Сангийн яам хүлээдэг. Сангийн яаманд СТОУС-ыг зохих хэмжээнд цаг алдалгүй, чанарын шаардлагад нийцүүлэн боловсруулах хөрөнгө нөөц хангалтгүй байна. Иймд Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн стандартууд нь СТОУС-ын 2003 оны орчуулганд суурилсан учраас хоцрогдсон гэсэн үг.
- СХЗҮТ болон түүний дэргэдэх Нягтлан бодох бүртгэлийн дэд хороо нягтлан бодох бүртгэл, аудитын стандартуудыг *баталдаг*. Нягтлан бодох бүртгэл, аудитын нарийн төвөгтэй стандартуудыг хянан үзэхэд шаардагдах мэргэжлийн чадавхи СХЗҮТ-д дутагдаж байна. Үүнтэй холбогдуулан нэг зүйлийг дурдахад СХЗҮТ-ийн дэргэдэх Нягтлан бодох бүртгэлийн дэд хороог Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн аргачлал, бодлогын газрын дарга тэргүүлдэг нь ашиг сонирхлын зөрчлийг агуулж байна.
- МБ болон СЗХ эцэст нь банкууд болон ББСБ, компаниудад тус тус зориулсан нягтлан бодох бүртгэлийн журмыг СТОУС-д нийцүүлэн *боловсруулан тогтоох* мэргэжлийн үүрэг хүлээдэг. Гэвч эдгээр журмуудыг СТОУС-д нэмэлт өөрчлөлт орох бүрт өөрчлөөд байж амждаггүй учраас банк, компаниуд СТОУС-ын өөр өөр жилийн хувилбарыг дагаж мөрдөхөд хүрдэг.

Компаниуд жил бүр АОУС-д нийцсэн хараат бус бие даасан аудит хийлгэх үүрэгтэй. Гэхдээ аудиторын бие даасан байдал нь асуудал дагуулсан хэвээр байна. Аудитын тухай хуульд заасны дагуу банк, компаниуд нийтээрээ жил бүр аудитад хамрагдах үүрэгтэй. Монгол Улсын компаниудын аудитын асуудлыг Аудитын тухай хуулиар зохицуулдаг бөгөөд хуулийн зохицуулалт нь АОУС-д суурилсан байдаг (Аудитын тухай хуулийн 8.1, 8.2-р заалт). Гэхдээ 2003 оны АОУС-ыг ашигласан байдаг учраас хэд хэдэн гол асуудлуудыг орхигдуулсан байна. Тухайлбал, хууль дүрмийг хэрэгжүүлэгч төрөл бүрийн байгууллагуудын үүрэг хариуцлага, хууль дүрмийг зөрчсөн тохиолдолд оногдуулах хариуцлага, хараат бус бие даасан байдал зэрэг болно.

Хууль тогтоомжинд зааснаар хөндлөнгийн аудиторууд хараат бус бие даасан байх үүрэгтэй хэдий ч (Компанийн тухай хуулийн 91.4-р заалт, Аудитын тухай хуулийн 21.1-р заалт) ихэнх аудиторуудын үйл ажиллагаа ашиг сонирхлын зөрчилд автагдсан байна. Тухайлбал, аудитын компаниуд үйлчлүүлэгчиддээ аудитын бус үйлчилгээ үзүүлэх, тэдгээртэй ямар нэгэн байдлаар холбоотой байх, тэдгээрийн үнэт цаасыг эзэмшихийг хориглодог. Бодит байдал дээр аудитын компаниуд нягтлан бодох бүртгэл хөтлөх, татварын тайлан гаргах, зөвлөлгөөний чиглэлээр үйлчилгээ үзүүлэх нь элбэг байна. Мөн түүнчлэн Аудитын тухай хуулинд хамгийн сүүлд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр компаниуд хөндлөнгийн аудитораа гурван жил тутамд сольж байх үүрэгтэй. Гэтэл энэхүү заалт нь компанийн сайн засаглалд сөргөөр нөлөөлж байна хэмээн компаниудын үзэж байна. Учир нь ахлах аудитыг биш аудитын компанийг бүтнээр нь солисноор тухайн компанийн үйл ажиллагааг бүрэн дүүрэн

Зарчим V.C: Хараат бус бие даасан, мэргэжлийн шаардлага хангасан, мэргэшсэн хөндлөнгийн аудитораар жил бүр аудит хийлгэнэ.
Хэрэгжсэн байдал:
Хэсэгчлэн хэрэгжсэн

ойлгож эхэлж байгаа үед аудитораа алдаж байна. Хамгийн гол нь шинэ тутам хөгжиж байгаа зах зээлд зөвхөн шаардлага хангасан аудитын компаниар солих үүрэгтэй байна. Цаашилбал, олон тооны жижиг аудитын компаниуд үйлчилгээний орлогоо нэг том үйлчлүүлэгчээс бүрдүүлдэг учраас хараат бус бие даасанд тооцогддоггүй. Эцэст нь Монгол Улсын аудиторын хараат бус бие даасан байдалд хяналт тавих бие даасан хяналтын байгууллага байхгүй байна. ТУЗ-үүд мөн аудиторын хараат бус бие даасан байдлыг хувьцаа эзэмшигчдэд баталгаажуулдаггүй.

Тодорхой шаардлага, мэргэжлийн шалгуур хангасан байдлаар аудиторуудад тусгай зөвшөөрөл олгож, хүчингүй болгодог. Аудитын тухай хуульд зааснаар Сангийн яамнаас аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компаниуд аудит хийх эрхтэй байна. МУМНБХ-д нягтлан бодох бүртгэл, аудитын шалгалтуудыг зохион байгуулах, Монгол Улсын мэргэжлийн ёс зүйн дүрмийг баталж мөрдүүлэх, мэргэжлийн давтан сургалт зохион байгуулах эрх албан ёсоор олгогдсон. Хөндлөнгийн аудиторын эрх авахын тулд тухайн хүн таван жилийн хугацаатай гэрчилгээтэй байхаас гадна Сангийн яамнаас тусгай зөвшөөрөл авсан аудитын компанид (одоогоор 51 компани байна) аудитын ажил хийж байх шаардлагатай. KPMG, Ernst & Young гэсэн олон улсын хоёр аудитын компани Монгол Улсад үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй. Өнөөдрийн байдлаар Монгол Улсад нийт 1,718 хөндлөнгийн аудитор бүтгэлтэй байдгаас 355 нь шалгалтын гурван шатыг бүгдийг нь давсан байна (гурван шатыг давахад ойролцоогоор долоон жил шаардлагатай байдаг). Гэхдээ аудитын шалгалтын материалд учир дутагдалтай талууд байгаагийн нэг жишээ нь дээд шатны аудит, компанийн тайлагналын асуудал бүрэн дүүрэн хамрагдаж чадахгүй байна. Дотоодын аудитын компаниуд ихэнх нь жижиг компаниуд байдаг бөгөөд үйлчлүүлэгчиддээ санхүүгийн тайлан тэнцэл гаргахад туслалцаа үзүүлэх, дараа нь тэдгээр тайлан тэнцэлд аудит хийхэд илүү их анхаарч байгаа нь ашиг сонирхлын зөрчлийн тод жишээ юм.

Сангийн яам аудитын стандартыг мөрдүүлж, зохих байдлаар тодорхойлсон үүрэг хариуцлагатай учраас тухайн мэргэжлээс хараат бус байж чаддаг. Гэхдээ шаардлагатай хөрөнгө нөөц дутагдалтай байна. Аудитын хуулийн дагуу Сангийн яам нь аудитын мэргэжил, үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй байгууллага мөн. Сангийн яамны үйл ажиллагаа хууль эрх зүй, зохицуулалтын мөрдөлтөнд чиглэдэг боловч АОУС-ын мөрдөлт ямар байгаад чанарын үнэлэлт дүгнэлт өгөх хөрөнгө нууц байхгүй байна. МУМНБХ-д хуулийн дагуу олгосон эрх байхгүй хэдий ч өөрсдийн гишүүдээ чанарын баталгааны хөтөлбөрт хамруулаад байна. Гэвч өөрийн ажлаа хянан дүгнэж, ашиг сонирхлын зөрчилд автагдсан энэхүү мэргэжил хөрөнгө оруулагчдын шаардаж байгаа баталгааг гаргаж өгч чадахгүй байна. МУМНБХ-ийн Ёс зүйн хороо ёс зүйн дүрмийн мөрдөлтөнд хяналт тавих чиглэлээр өдий болтол ямарч арга хэмжээ аваагүй учраас сайн ажиллаж чадахгүй байна. Сангийн яам, МУМНБХ-ийн аль алинд хариуцлагын арга хэмжээ авч, торгууль ногдуулах эрх мэдэл байхгүй байна.

МУМНБХ аудит, ёс зүйн стандартуудыг боловсруулж, тайлбар гаргадаг хэдий ч ийм эрх мэдэл олгогдоогүй. МУМНБХ нь эрх мэдэл олгогдоогий хэдий ч IFAC-ийн Ёс зүйн дүрмийн хуучин хувилбар дээр үндэслэн аудитын үйл ажиллагааны ёс зүйн дүрмийг баталсан (Аудитын тухай хуулийн 8.1-2-р заалт).

Компанийн ТУЗ-өөс тухайн аудитор хараат бус бие даасан, мэргэжлийн шаардлага хангасан, анхаарал болгоомжтой ажилласан, аудитын бус ажил гүйцэтгэсэн гэдгийг хувьцаа эзэмшигчдэд мэдээлдэггүй.

Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдэд тайлагнах албан ёсны үүрэг байхгүй бөгөөд бодит байдал дээр зөвхөн гүйцэтгэх захирал буюу томоохон өмчлөгчид тайлагнадаг. Хуулийн дагуу хувьцаа эзэмшигчид биш харин ТУЗ хөндлөнгийн аудиторыг томилж, түүнд олгох хөлсийг тогтоох эрхтэй байгаа нь нийтлэг жишгээс гажсан байна (гэхдээ хувьцаа эзэмшигчид хяналтын зөвлөлийг томилж хөндлөнгийн

Зарчим V.D: Хөндлөнгийн аудиторууд хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээх бөгөөд аудитыг мэргэжлийн зохих түвшинд хийж гүйцэтгэх үүргийг компанийн өмнө хүлээсэн байна. **Хэрэгжсэн байдал:** Хэрэгжээгүй

аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг).¹⁸

Хөндлөнгийн аудиторууд хариуцлагын арга хэмжээ авах, торгууль ногдуулах, хариуцлага хүлээдэггүй effective or dissuasive. Хуурамч дүгнэлт гаргасан эсвэл аудитын үйл ажиллагаа зохих анхаарал болгоомжгүй явуулсан гэх үндэслэлээр хувьцаа эзэмшигчдээс хөндлөнгийн аудиторын эсрэг нэхэмжлэл гаргасан тохиолдол бүртгэгддэггүй байна. Тийм ч учраас аудитын компаниуд шүүхэд дуудагдах эрсдэлээс өөрсдийгөө хамгаалж даатгал хамрагддаггүй (хууль эрх зүй, зохицуулалтын хүрээнд ч мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдах шаардлага тусгагдаагүй). Нөгөө талаас, нэгэн хувийн арилжааны банкинд 14 тэрбум төгрөг буюу 11,864,400 ам. долларын санхүүгийн булхайг илрүүлж чадаагүй учраас Монгол Улсын Засгийн газар хоёр аудитын компанийг аудитын үйл ажиллагааг зохих түвшинд явуулж чадаагүй хэмээн саяхан дүгнэсэн юм.

Зарчим V.E: Мэдээ мэдээллийг түгээх сувгууд нь холбогдох мэдээллийг хэрэглэгчдэд тэгш, хямд өртөг зардлаар цаг хугацаанд нь өгөх нөхцлийг хангасан байна. **Хэрэгжсэн байдал:** **Хэрэгжээгүй**

Компаниуд чухал ач холбогдолтой бүхий л мэдээллийг цаг алдагдалгүй нийтэд мэдээлдэггүй. Бодит байдал дээр компаниуд чухал ач холбогдолтой мэдээ мэдээллийг цахим хуудаснаа тавьдаггүй эсвэл (мэдээллийн агуулга ихтэй) жилийн тайлан гаргадаггүй. Компаниуд холбогдох мэдээ мэдээллийг зөвхөн Сангийн яам (татварын зорилгоор), СЗХ, МХБ-д мэдээлэх үүрэгтэй. МХБ зарим компанийн санхүүгийн тайлан тэнцлийн хурааггүйг өөрийн цахим хуудсан тавьдаг. СЗХ-ны хувьд саяхнаас ийм төрлийн мэдээллийг нийтэд танилцуулах үүрэгтэй болсон хэдий ч бодит байдал дээр хэрэгжүүлээгүй байна. Компаниуд чухал ач холбогдолтой үйл явдлын мэдээ мэдээллийг нийтэд танилцуулахгүй байгаагаас гадна ТУЗ-ийн гишүүд гэх мэт компанийн дотоод мэдээллийг эзэмшигч этгээд зарим нэгэн зүйлийг мэдээлж шийдвэрлээгүй асуудал хэвээр байна. Хөрөнгө оруулагчид үндсэндээ хөрөнгийн биржид бүртгэлтэй компанийн санхүүгийн үр дүнгийн талаар хангалттай мэдээлэл авах боломжгүй байна. Мөн түүнчлэн компанийн дотоод мэдээлэл эзэмшигчидтэй харьцуулахад тэгш бус орчинд ажиллаж байна.

Зарчим V.F: Шинжээч, брокер, зээлийн зэрэглэл тогтоогч байгууллага болон бусад этгээдийн дүн шинжилгээ, зөвлөлгөө нь ашиг сонирхлын материаллаг зөрчилгүй байх бөгөөд ийм зөрчил нь тэдгээрийн дүн шинжилгээ, зөвлөлгөөний шударга байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй. **Хэрэгжсэн байдал:** **Хэрэгжээгүй**

Компанийн засаглалын тогтолцооны хүрээнд зээлийн зэрэглэл тогтоогч байгууллагуудын ашиг сонирхлын (бодит буюу болзошгүй) зөрчил тусгаадаггүй. Монгол Улсад зээлийн зэрэглэл тогтоогч байгууллагууд байдаггүй бөгөөд IOSCO-ийн Зээлийн зэрэглэл тогтоогч байгууллагын үйл ажиллагааны тухай зарчмын мэдэгдлийг хууль эрх зүй, зохицуулалтын хүрээнд тусгаж өгөөгүй байна. Монгол Улсын зах зээл дээр брокерийн пүүсүүд үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч IOSCO-ийн Үнэт цаасны худалдан борлуулах шинжээчийн ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэх тухай зарчмын мэдэгдлийг бүрэн дүүрэн хэрэгжүүлээгүй байна. Эцэст нь хүчин төгөлдөр компанийн засаглалын тогтолцооны хүрээнд санхүүгийн зуучлагчид, ялангуяа брокерууд ашиг сонирхлын зөрчлүүд, тэдгээрийг хэрхэн зохицуулж байгаа талаар нийтэд мэдээлэх үүрэг, шаардлага байхгүй байна.

¹⁸ Компанийн тухай хуулийн 76.1.10-р заалт

Зөвлөмж

 Богино хугацаанд хүрэх эн тэргүүний зорилтууд Дунд хугацаанд хүрэх эн тэргүүний зорилтууд Урт хугацаанд хүрэх эн тэргүүний зорилтууд

Монгол Улсын Компанийн засаглалын тогтолцооны OECD Зарчмуудыг 5-р бүлгийн заалтуудтай нийцэхгүй байгаа асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Монгол Улс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Үүнд:

- *СТОУС-ыг дагаж мөрдөхийг зөвхөн олон нийтийн ашиг сонирхол бүхий компаниудаас шаардах*; Сангийн яам хөрөнгийн биржид бүртгэлгүй компаниуд, ЖДҮ-д зориулсан нягтлан бодох бүртгэлийн хялбарчилсан стандартыг боловсруулах.
- *Монгол Улсын Засгийн газар СТОУС, АОУС-ыг “өөрчлөн тохируулах” бус “батлан мөрдөх”*, өөрөөр хэлбэл СТОУС-ыг нягтлан бодох бүртгэлийн үндэсний стандартад өөрчлөн тохируулахын оронд шууд батлах.
- *Хууль дүрмийг хэрэгжүүлэгч бүхий л байгууллагууд хараат бус бие даасан аудитад хамрагдсан санхүүгийн тайлан тэнцлийг хугацаа алдалгүй нийтэд мэдээлэх шаардлагыг хатуу чанд мөрдүүлэх*, мөн санхүүгийн бус мэдээ мэдээллийг нийтэд мэдээлэх. Улирлын тайлан тэнцлийг хувьцаа эзэмшигчдэд мөн танилцуулах.
- *Компанийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт оруулж хөндлөнгийн аудиторыг ТУЗ биш хувьцаа эзэмшигчид сонгохоор зааж өгөх.*
- *Сангийн яам (байгуулагдсанахаа дараа бие даасан хяналтын байгууллага) чанарын хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх*, МУМНБХ ч мөн өөрийн гишүүдийн үйл ажиллагааны чанарт хяналт шинжилгээ хийх.
- *Аудитын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж аудитын компанийг тэр чигээр нь бус зөвхөн ахлах аудиторыг тодорхой давтамжтайгаар сольж байхаар заах.*
- *Засгийн газар одоогийн хяналтын тогтолцоонд байгаа хяналтын зөвлөлийн үүрэг ролийг эргэн хянан бодолтой байгаа*, нэн ялангуяа аудиторуудыг хувьцаа эзэмшигчид баталдаг болсон нөхцөлд хөндөнгийн аудитын чиг үүрэг, аудитын хорооны үйл ажиллагаатай харьцуулах.

Зөвлөмжийн дэлгэрэнгүйг энэхүү тайлангийн “Бодлогын зөвлөмж ба үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 4-р хэсгээс харна уу.

CHAPTER VI

The Responsibilities of the Board

Хэрэгжилтийн байдалд хийсэн шинжилгээ

Монгол Улс OECD-ийн Зарчмуудын 4-р бүлгийг хэсэгчлэн хэрэгжүүлсэн байна. Тодруулбал:

Монгол Улсад нэг шатлалтай ТУЗ-ийн загвар мөрдөгддөг, өөрөөр хэлбэл ТУЗ-ийн бүрэлдэхүүнд энгийн гишүүд болоод бие даасан гишүүд зэрэг багтдаг. ТУЗ нь компанийн дотоод мэдээллийг эзэмшигчид буюу томоохон хувьцаа эзэмшигчид, тэдгээрийн төлөөлөгчид, гүйцэтгэх захирлуудаас бүрдсэн байх нь практик дээр олонтаа байна. Компаниуд хамгийн цөөндөө 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ёстой (практик дээр ч байдаг) байгаа нь ихэнх компаниуд харьцангуй жижиг байдгийг харгалзаж үзвэл хэтэрсэн үзүүлэлт байж болох юм. Гол чухал асуудлууд, мөн түүнчлэн зөрчилд хүргэж болзошгүй асуудлууд, тухайлбал санхүүгийн тайлагнал, томилгооны нэр оруулах, шан харамжийн асуудлаар ТУЗ-ийн дэргэд хороо байгуулан ажиллаж буй компаниуд цөөхөн байна. ТУЗ-үүд ихэнхдээ хуульд заасан жилд дөрвөн удаа зохион байгуулах ёстой хурлыг зарлан хуралдуулдаг ч зарим нь огт хуралддаггүй. Монгол Улсад бүртгэлтэй компаниуд “хяналтын зөвлөл” гэгчийг байгуулах ёстойг тэмдэглэх нь зүйтэй. Хяналтын зөвлөлийг хувьцаа эзэмшигчдийн сонголтоор байгуулж, тэдэнд тайлагнадаг. Практик дээр хяналтын зөвлөл нь аудитын нэг хэлбэр болдогоос гадна ямар нэгэн үүрэг гүйцэтгэсэн хяналтын зөвлөл ховор болов уу.

Зарчим VI.A: ТУЗ-ийн гишүүд нь бүрэн мэдээлэл дээр үндэслэж шийдвэр гаргах бөгөөд сайн санаа агуулж, зохих хэмжээний хичээл зүтгэл гаргаж, анхаарал тавин компани болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг бүрэн хамгаалж ажиллана. **Хэрэгжсэн байдал:** **Хэсэгчлэн хэрэгжсэн**

Зарчим VI.B: Хувьцаа эзэмшигчдэд янз бүрээр нөлөөлөхүйц шийдвэр яригдаж байгаа үед ТУЗ бүх хувьцаа эзэмшигчдэд адил тэгш хандах ёстой. **Хэрэгжсэн байдал:** **Хэсэгчлэн хэрэгжсэн**

Зарчим VI.C: ТУЗ нь ёс зүйн дээд хэм хэмжээг мөрдөж ажиллаж, оролцогч талуудийн ашиг сонирхлыг харгалзаж үзэх ёстой. **Хэрэгжсэн байдал:** **Хэрэгжээгүй**

Компанийн засаглалын тогтолцоонд анхаарал болгоомж, үнэн байдлын үүргийг ерөнхий байдлаар тодорхойлсон байна. Тухайлбал, ТУЗ-ийн гишүүд, гол захирлуудын гүйцэтгэх үүргийг компанийн үүсгэн байгуулах дүрэм, ТУЗ-өөс баталсан журмаар тодорхойлж, ажил үүргээ сайн санааны үүднээс компанийн ашиг сонирхолд нийцүүлэн гүйцэтгэх учиртай. МУКЗД эсвэл шүүхийн шийдвэрүүд нь энэхүү тодорхойлолтыг тодруулдаггүй бөгөөд асуудлыг шийдвэрлэх холбогдох хууль тогтоомжийг зааж өгдөггүй. Үүнтэй холбоотойгоор нэг зүйлийг дурьдахад ТУЗ-ийн дарга (Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7.6, 7.7-р заалт), үндсэн албан хаагчид (Компанийн тухай хуулийн 93.3-р заалт)-ын аль аль нь үйл ажиллагааны жилийн тайлан, санхүүгийн тайлан тэнцлийг баталгаажуулан гарын үсэг зурж, тэдгээрийн үнэн бодит байдлыг хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцах албагүй. Цаашилбал, алдагдлын тохируулга хийх, ТУЗ-ийн гишүүдийн алдаатай үйл ажиллагааны улмаас компанид учирсан хохирлыг барагдуулах журамтай байхыг МУКЗД-ээр зөвшөөрдөг бөгөөд шаардлагатай нөхцөлд ТУЗ-ийн гишүүдэд харуцлагын даатгал олгохоор заажээ (МУКЗД-ийн 3.3.4-р заалт).

ТУЗ-ийн гишүүд нийт хувьцаа эзэмшигчид, тэр дундаа жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийн үүднээс ажил үүргээ гүйцэтгэх үүрэг хүлээгээгүйгээс гадна зүйтэйд тооцдоггүй. Өмчлөлийн төвлөрөл их байгаатай холбоотойгоор бодит байдал дээр ТУЗ-ийн гишүүдийн ихэнх нь өөрсдөө томоохон хувьцаа эзэмшигчид эсвэл тэдгээрийн төлөөлөл нь байдаг. Цаашилбал төрийн өмчийн оролцоо их байгаагаас олон компанийн ТУЗ-д төрийн албан хаагчид байдаг бөгөөд тэднийг чөлөөтэй сольж халж байдаг. Төрийн албан хаагч компанийн ТУЗ-д зөвхөн төрийн ашиг сонирхлыг төлөөлөх учиртай тул компанийн эсвэл нийт хувьцаа эзэмшигчдийн, тэр дундаа жижиг хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлын үүднээс ажил үүргээ гүйцэтгэдэг ТУЗ-ийн гишүүд ховор. Томоохон хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхол ихэнхдээ хангагдаж байна.

ТУЗ-өөс өөрийн гишүүд, ажилтнууд, компанийн ажилчдын ёс зүйн дүрмийг тогтоож өгдөггүй. Тодруулбал, компанийн засаглалын тогтолцооны хүрээнд компаниуд ёс зүйн дүрмийг боловсруулж гаргах үүрэг, шаардлага байдаггүй бөгөөд

бодит байдал дээр ч компаниуд гаргахгүй байна. Цаашилбал, хувь сонирхлын бүлгийн эрх ашгийг харгалзан үзэх үүрэг, шаардлага ТУЗ-ийн гишүүдэд байхгүй бөгөөд бодит байдал дээр цөөн хэдэн компанийн ТУЗ үүнийг харгалзаж байна. Нөгөө талаас компаниуд холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, цаашилбал дотоод журмын мөрдөлтийн хангах үндсэн үүрэг бүхий аудитын хороог байгуулах нь зүйтэй гэж заасан байна.

Зарчим VI.D: ТУЗ нь тодорхой гол чиг үүргийг гүйцэтгэнэ.

Хэрэгжсэн байдал:
Хэсэгчлэн хэрэгжсэн

ТУЗ-ийн үндсэн чиг үүрэг болох хувьцаа эзэмшигчдийн нэрийн өмнөөс гүйцэтгэх удирдлагыг ажлын удирдамжаар хангаж, хяналт тавих, компанийн засаглал, хяналт аудит, эрсдэлийн удирдлагын оновчтой тогтолцоогоор хангах үүргийг ханган биелүүлэхэд хууль эрх зүй, зохицуулалтын тогтолцоо зөвхөн хэсэгчилсэн удирдамж болж байна. Хүснэгт 2-т хууль эрх зүй, зохицуулалтын холбогдох хэм хэмжээ, мөн ТУЗ-ийн үндсэн чиг үүргийг хэрэгжилт ямар байгааг харуулав.

Хүснэгт 2: ТУЗ-ийн үндсэн чиг үүрэг: хуулийн заалт, бодит байдлыг харьцуулбал		
1. Стратегийн хяналт	☐	Компанийн тухай хуулийн 76.1.1: ТУЗ нь компанийн гол бодлогыг тодорхойлно.
	☒	Бодит байдал дээр ТУЗ-ийн үүрэг нь тодорхой бус. Олон компани дээр ТУЗ-үүд нь компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцдог. Албан ёсны стратеги боловсруулж, ажлын гүйцэтгэлийн үзүүлэлт тогтоодог ТУЗ-үүд цөөхөн.
2. Компанийн засаглалын үйл ажиллагаанд хяналт тавих	☒	МУКЗД-ийн 5.7.10 заалт: МУКЗД-д нийцэхгүй байгаа аливаа асуудлыг жилийн тайлангаар тайлбарлана. Нөгөө талаас, компанийн засаглалын тогтолцоо, тэр дундаа МУКЗД-ийн хүрээнд ТУЗ өөрийн ажлын гүйцэтгэлд жил бүр үнэлэлт дүгнэлт өгөх хөшүүрэг байхгүй байнаш.
	☒	Бодит байдал дээр ТУЗ-үүд засаглалын бодлогыг тодорхойлдоггүй, хэрэгжилтэнд хяналт тавьдаггүй, эсвэл өөрийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгдөггүй.
1. Гол захирлуудыг сонгох/хөлсийг тогтоох/хяналт тавих/шинээр томилох	☐	Компанийн тухай хуулийн 76.1.8-р заалт, 9-р зүйл: ТУЗ нь компанийн захирлуудыг сонгож, чөлөөлөх, мөн түүнчлэн гол захирлуудтай хийх гэрээний нөхцөл, тэдэнд олгох шагнал урамшууллын хэмжээг тохирох үүрэгтэй.
	☒	Бодит байдал дээр ТУЗ-үүд захирлуудыг сонгож, чөлөөлж, тэдэнд олгох цалин харамжийг тогтоодог. Харин төрийн өмчит аж ахуйн нэгж дээр Засгийн газар Гүйцэтгэх захирлыг томилж байна. Компанийн захирлын залгамж халааг бэлтгэх төлөвлөлт хийгдэхгүй байна.
4. Захирлууд, ТУЗ-ийн гишүүдийн цалин харамжийг урт хугацааны ажлын гүйцэтгэлтэй уялдуулах	☒	Цалин харамжийг урт хугацааны ажлын гүйцэтгэлтэй уялдуулсан цалингийн бодлого боловсруулж нийтэд мэдээлэх үүрэг, хөшүүрэг ТУЗ-д байхгүй байна.
	☒	Бодит байдал дээр ТУЗ-ийн бие даасан гишүүд үйлчилгээнийхээ төлөө бага хөлс авч, банкууд, төрийн өмчийн томоохон аж ахуйн нэгжийн хэмнэлт болж, ТУЗ-ийн хөлс, ажлын гүйцэтгэлтэй ямар ч холбоо хамааралгүй байна.
5. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх үйл	☐	Компанийн тухай хуулийн 66.4.4-р заалт: ТУЗ-ийн гишүүнээр томилохоор санал болгож буй нэр дэвшигчийн тухай мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулна.

явц ил тод байх		МУКЗД-ийн 3.4.1-р заалт: Нэр дэвшүүлэх хороо нэр дэвшигчдийг судалж, ямар шаардлага хангахгүй байгааг мэдэгдэн, ТУЗ-д санал оруулдаг.
	☒	Бодит байдал дээр ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх үйл явцыг тохоорон хувьцаа эзэмшигчид хяналтандаа авч гадны хүмүүсээс далд байдаг.
6. Ашиг сонирхлын зөрчилд хяналт тавих	☒	Компанийн тухай хуулийн 89.1-р заалт: Ашиг сонирхлын зөрчил агуулсан ажил гүйлгээг ТУЗ-ийн бие даасан гишүүдээр батлуулна.
	☒	Бодит байдал дээр ТУЗ-үүд холбогдох эдгээдийн зүйл бус ажил гүйлгээнд хяналт тавьж, түүнээс сэргийлэхэд чиглэсэн дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж чаддаггүй.
7. Санхүүгийн тайлагнал, тэр дундаа хараат бус аудит, дотоод хяналтад хяналт тавих	☒	НББ-ийн тухай хуулийн 18-р зүйл: Гүйцэтгэх удирдлага компанийн дотоод аудитын тогтолцоог бүрдүлнэ. МУКЗД-ийн 1.3.1-р заалт: ТУЗ-ийн үндсэн үүрэгт дотоод аудитын үйл ажиллагаа хамаарна.
	☒	Бодит байдал дээр харьцангуй "сайн" буюу эрсдэл, дотод аудит, дүрэм журам мөрдөлтийг хангах, хяналтын чиг үүргүүд нь бие даасан байдаг дотоод хяналтын тогтолцоотой байгууллагууд нь зөвхөн томоохон банкууд байна. Ихэнх банк, компаниудад дотоод хяналтын чиг үүрэг муу хөгжсөн байна.
8. Мэдээ мэдээллийг нийтэд ил тод болгож мэдээлэх үйл явцад хяналт тавих		МУКЗД-ийн 5.4-р заалт: Захирлууд мэдээ мэдээллийг ТУЗ-ийн хяналтан дор нээлттэй болгох үүрэгтэй.
	☒	Бодит байдал дээр ТУЗ-үүд компанийн мэдээ мэдээллийг нээлттэй болгож буй байдалд хяналт тавьдаггүй бөгөөд цөөн хэд нь хөрөнгө оруулагчийн харилцааны чиг үүргийг бий болгосон байдаг.

Зарчим VI.E: ТУЗ нь компанитай холбоотой асуудлаар бодит, бие даасан үнэлэлт дүгнэлт өгөх боломжтой байна. **Хэрэгжсэн байдал:** Хэсэгчлэн хэрэгжсэн

ТУЗ-ийн бие даасан гишүүдэд ашиг сонирхлын зөрчил байж болзошгүй ажлыг хариуцуулах нь зүйтэй байдаг хэдий ч бодит байдал дээр хариуцуулдаггүй.

Тухайлбал, ТУЗ-ийн гишүүдийн дор хаяж 1/3-ийг бие даасан гишүүдээс бүрдүүлэх нь зүйтэй байдаг (МУКЗД-ийн 3.2.3-а-р заалт). МУКЗД-д бие даасан гишүүдийн үүргийг нийтлэг жишигт нийцүүлэн тодорхойлсон байх ёстой хэдий ч хувьцаа эзэмшигчид нь өөрсдөө ТУЗ-ийн гишүүд байх тохиолдлыг тусгаагүй учраас нийтлэг жишигт бүрэн нийцэхгүй байна. Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн даргын албан тушаалыг нийтлэг жишигт нийцүүлэн салгасан байх ёстой (Компанийн тухай хуулийн 80.3-р заалт). Гэтэл бодит байдал дээр ТУЗ-ийн бүрэлдэхүүнд компанийн дотоод мэдээллийг эзэмшигчид багтсан байх нь хувийн хэвшил (захирлууд болон өмчлөгчид), төрийн өмчит аж ахуйн нэгжүүд (сайдын тушаалаар тодорхой хугацаагүйгээр томилогддог төрийн албан хаагч)-ийн аль алинд элбэг байна. ТУЗ-д бие даасан гишүүнтэй байх нь хууль дүрмээс илүү онцгой тохиолдол болоод байна.

ТУЗ-ийн хороодын үйл ажиллагааг тогтоосон тодорхой бөгөөд тунгалаг журамтай байх. МУКЗД-д зааснаар компани аудит, цалин хөлс, нэр дэвшүүлэх зэрэг хороог ТУЗ-ийн дэргэд байгуулж болно (МУКЗД-ийн 3.2-р заалт). Мөн түүнчлэн эдгээр хорооны бүрэлдэхүүнд ТУЗ-ийн бие даасан гишүүдийг томилохыг зөвлөмж болгодог. Гэхдээ хороодын эрх мэдэл, бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журам зэрэг мэдээллийг нийтэд мэдээлэх шаардлагагүй байхаар заасан. Бодит байдал дээр харин компаниудын ТУЗ-ийн дэргэд хороод байдаггүй. Нөгөө талаас, бүх банкууд хэмжээнээсээ үл хамааран аудит, эрсдэл, цалин харамжийн асуудлыг хариуцсан хороодыг ТУЗ-ийн дэргэд байгуулах үүрэгтэй бөгөөд бодит байдал дээр ч байгуулсан

байдаг. Гэхдээ байгуулагдаад удаагүй байгаа учраас үйл ажиллагаа нь тогтворжоогүй байна.

ТУЗ-ийн гишүүд үүргээ ханган биелүүлэх, биелүүлэх эрмэлзэл дүүрэн байгааг нийтэд харуулах талаар хууль эрх зүй, зохицуулалтын тогтолцоо нь удирдамж болж чаддаггүй. ТУЗ-ийн гишүүдийн томилогдсон хугацаа, ажлын туршлага, орлого, ТУЗ-д хашиж буй бусад албан тушаал, ТУЗ болоод хорооны хурлын ирцийн мэдээлэл зэргийг нийтэд мэдээлэх үүрэг, шаардлага компаниудад байхгүй байна. Мөн түүнчлэн шинээр томилогдсон ТУЗ-ийн гишүүдэд чиглэл олгох, цаашилбал ТУЗ-ийн гишүүдийг сургалтанд тогтмол хамруулах шаардлага байхгүй байна.

Зарчим VI.F: Үүрэг хариуцлагаа биелүүлэх үүднээс ТУЗ-ийн гишүүд үнэн зөв холбогдох мэдээллийг хугацаанд нь авах оломжтой байна.
Хэрэгжсэн байдал:
Хэсэгчлэн хэрэгжсэн

Захирлууд ТУЗ-д үнэн зөв, цаг хугацааны хувьд хойрогдоогүй холбогдох мэдээ мэдээлэл гаргах өгөх үүрэг, шаардлага байхгүй байна. Нөгөө талаас ТУЗ-ийн гишүүдийн анхаарал тавих үүргийнхээ хүрээнд эдгээр мэдээллийг гаргуулах шаардлага байхгүй байна. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь компанийн тухай мэдээ мэдээллийг гүйцэтгэх удирдлагаас ТУЗ-д хүргэхэд дэмжлэг үзүүлэх учиртай бөгөөд түүний үүргийг МУКЗД-д хэсэгчлэн дурьдаж зөвхөн хувьцаа эзэмшигчдэд мэдээ мэдээлэл гаргаж өгөхөөр хязгаарласан байна. Цөөн хэдэн томоохон банк, компаниудад мэргэжлийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар ажиллаж байна. ТУЗ-ийн гишүүд хараат бус бие даасан зөвлөлгөөг гаднаас чөлөөтэй авч, шийдвэр гаргахдаа ашиглах боломжийн талаар компанийн засаглалын тогтолцоонд тодорхой заасан зүйл байхгүй байна.

Зөвлөмж

Монгол Улсын Компанийн засаглалын тогтолцооны OECD Зарчмуудыг 6-р бүлгийн заалтуудтай нийцэхгүй байгаа асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Монгол Улс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Үүнд:

Богино хугацаанд хүрэх

■ **МУКЗД-д нэмэлт өөрчлөлт оруулж дараахь зохицуулалтыг бий болгож.** Үүнд: (1) анхаарал болгоомж, үнэнч байдлын үүргийн хүрээг өргөжүүлэх; (2) ТУЗ-ийн гишүүдийн ёс зүйн дүрмийг батлан мөрдүүлэхийг дэмжих; (3) ТУЗ-ийн үүргийг ханган биелүүлэхэд илүү сайн удирдамжаар хангах, тухайлбал: гүйцэтгэх удирдлагад стратегийн удирдамж өгч, хяналт тавих, компанийн засаглалын бодлогыг хянах, succession бодлогыг батлах; (4) ТУЗ-ийн бие даасан гишүүний тодорхойлолтыг боловсронгуй болгох.

Дунд хугацаанд хүрэх эн тэргүүний зорилтууд

■ **Компанийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж** ТУЗ-ийн гишүүдийн тоог хамгийн багадаа 9 биш 7 байхаар заах.
■ **Төрийн өмчит аж ахуйн нэгжийн ТУЗ-д бүрэлдэхүүнд бие даасан гишүүдийг томилох.**
■ **ТУЗ-ийн гишүүд болоод ажилтнуудад зориулан компанийн засаглалын сургалт явуулах өндөр түвшний чадавхийг бий болгоход бүх оролцогч талууд дэмжлэг үзүүлэх.**

Урт хугацаанд хүрэх эн

■ **Компанийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж, хяналтын зөвлөлийг сайн дурын үндсэн дээр байгуулах эсвэл** хувьцаа эзэмшигчдэд тодорхой чиглэлээр тусгай аудит хийхийг шаардах эрх олгох.

Зөвлөмжийн дэлгэрэнгүйг энэхүү тайлангийн “Бодлогын зөвлөмж ба үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 4-р хэсгээс харна уу.

III. Хураангуй хүснэгт

Хүснэгт 1: OECD-ийн зарчмуудыг хэрэгжүүлсэн байдал, 2009		
№	Зарчим	ROSC үнэлгээ
I. Компанийн засаглалын үр дүнтэй тогтолцоо		Хэсэгчлэн хэрэгжсэн
I.A	Компанийн засаглалын ерөнхий тогтолцоо	Хэсэгчлэн хэрэгжсэн
I.B	Хэрэгжүүлэх боломжтой, тунгалаг хууль эрх зүйн орчин	Хэсэгчлэн хэрэгжсэн
I.C	Зохицуулах үүрэг хариуцлагыг тодорхой ялгаж заагласан	Бүрэн хэрэгжсэн
I.D	Зохицуулах эрх бүхий байгууллага, шударга байдал, нөөц хөрөнгө	Хэсэгчлэн хэрэгжсэн
II. Хувьцаа эзэмшигчдийн эрх ба өмчлөлийн гол чиг үүргүүд		Хэсэгчлэн хэрэгжсэн
II.A	Хувьцуу эзэмшигчдийн үндсэн эрх	Хэсэгчлэн хэрэгжсэн
II.B	Гол шийдвэр гаргалтанд оролцох эрх	Хэсэгчлэн хэрэгжсэн
II.C	Хувьцаа эзэмшигчдийн GSM эрх	Хэсэгчлэн хэрэгжсэн
II.D	Харилцан адилгүй хяналтыг ил болгох	Хэсэгчлэн хэрэгжсэн
II.E	Чиг үүргээ биелүүлэх нөхцлөөр хангагдсан хяналтын тогтолцоо	Үндсэндээ хэрэгжсэн
II.F	Өмчлөлийн эрхээ эдлэх боломжоор хангагдсан	Хамаарахгүй
II.G	Хувьцаа эзэмшигчид хоорондоо зөвлөлдөх боломжтой	Үндсэндээ хэрэгжсэн
III. Хувьцаа эзэмшигчдэд адил тэгш хандах		Үндсэндээ хэрэгжсэн
III.A	Бүх хувьцаа эзэмшигчдэд адил тэгш хандана	Үндсэндээ хэрэгжсэн
III.B	Байгууллагын дотоод мэдээллийг ашиглаж биржийн арилжаанд оролцохыг хориглох	Хэсэгчлэн хэрэгжсэн
III.C	ТУЗ-ийн гишүүд, удирдах ажилтнууд ашиг сонирхлоо ил болгох	Хэсэгчлэн хэрэгжсэн
IV. Компанийн засаглалд хувь сонирхлын бүлгийн гүйцэтгэх үүрэг		Хэсэгчлэн хэрэгжсэн
IV.A	Хувь сонирхлын бүлэгт хуулийн дагуу олгосон эрхийг хүндэтгэн эдлүүлэх	Хэсэгчлэн хэрэгжсэн
IV.B	Зөрчигдсөн эрхийг нөхөн төлөх	Бүрэн хэрэгжсэн
IV.C	Ажлын гүйцэтгэлийг сайжруулах механизм	Хэсэгчлэн хэрэгжсэн
IV.D	Мэдээ мэдээлэл олж авах	Хэрэгжээгүй
IV.E	“Шүтэл үүлээгч”-ийг хамгаалах	Хэрэгжээгүй
IV.F	Зээлдүүлэгчийн эрхийн тухай хууль, хуулийн хэрэгжилт	Хэсэгчлэн хэрэгжсэн
V. Мэдээллийг нээлттэй болгох, тунгалаг байдал		Хэсэгчлэн хэрэгжсэн
V.A	Мэдээллийг нээлттэй болгох стандарт	Хэсэгчлэн хэрэгжсэн
V.B	Нягтлан бодох бүртгэл, аудитын стандарт	Үндсэндээ хэрэгжсэн
V.C	Жил бүр бие даасан аудитад орох	Хэсэгчлэн хэрэгжсэн
V.D	Хөндлөнгийн аудиторуудад хариуцлага тооцдог байх	Хэрэгжээгүй
V.E	Мэдээ мэдээллийг шударгаар, хугацаанд нь тархаах	Хэрэгжээгүй
V.F	Ашиг сонирхлын зөрчлийн талаар судлах	Хэрэгжээгүй
VI. ТУЗ-ийн үүрэг хариуцлага		Хэсэгчлэн хэрэгжсэн
VI.A	Зохих хичээл зүтгэл гаргаж, анхааралтай ажиллах	Хэсэгчлэн хэрэгжсэн
VI.B	Бүх хувьцаа эзэмшигчдэд адил тэгш хандах	Хэсэгчлэн хэрэгжсэн
VI.C	Ёс зүйн дээд зэргийн хэм хэмжээг дагаж мөрдөх	Хэрэгжээгүй
VI.D	ТУЗ нь тодорхой заасан голлох чиг үүргийг гүйцэтгэнэ	Хэсэгчлэн хэрэгжсэн
VI.E	Бодит үнэлэлт дүгнэлт гаргах	Хэсэгчлэн хэрэгжсэн
VI.F	Мэдээ мэдээлэл олж авах	Хэсэгчлэн хэрэгжсэн

Тухайн зарчмын үндсэн шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт 95 хувь буюу түүнээс дээш байгаа нөхцөлд **бүрэн хэрэгжсэнд** (***) тооцно (Үндсэн шалгуур үзүүлэлтүүд болон тэдгээрийн хэрэгжилтийг үнэлэх Дэлхийн Банкны аргачлалыг Хавсралтанд харуулав). Үндсэн шалгуурт стандартыг хамруулж байгаа нөхцөлд уг стандартын бүхий л материаллаг талууд тодорхой заагдсан байна; дагаж мөрдөж буй байдлыг тооцож байгаа нөхцөлд уг байдал нийтлэг байна; хэрэгжилтийг хангах механизмыг тооцож байгаа нөхцөлд зохих, хүчин төгөлдөр механизмууд үйлчилж байна. Тухайн зарчмын үндсэн шалгуурын нэг буюу түүнээс олон холбогдох үзүүлэлтүүд бүх талаасаа бүрэн дүүрэн хэрэгжээгүй (хэрэгжилт 75 – 94.9 хувьтай) байгаа нөхцөлд **үндсэндээ хэрэгжсэнд** (**) тооцно. Тухайн

зарчмын үндсэн шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт 35-74.9 хувьтай байгаа нөхцөлд **хэсэгчлэн хэрэгжсэнд** (*) тооцно. Томоохон учир дутагдалтай талууд байгаа буюу тухайн зарчмын үндсэн шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт 35 хувьд хүрэхгүй байгаа нөхцөлд **Хэрэгжээгүй** (--) гэсэн үнэлгээ өгнө. Бүтэц зохион байгуулалт, хууль эрх зүй, эсвэл институцийн онцлогоос хамаарч OECD-ийн зарчмууд (эсвэл үндсэн шалгуур үзүүлэлтүүдийн нэг)-ыг дагаж мөрдөх боломжгүй нөхцөлд **Хамаарахгүй** (n/a) гэсэн үнэлгээ өгнө.

IV. Үйл ажиллагааны төлөвлөгөө ба бодлогын зөвлөмжүүд

Хүснэгт 3: Үйл ажиллагааны төлөвлөгөө

Монгол Улсын компанийн засаглалын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор дараах үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсрууллаа. Үүнд:

1. Монгол Улсын Компанийн засаглалын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, олон нийттэй зөвлөлдөх үйл ажиллагааг өргөн хүрээнд зохион байгуулах.

- Арга хэмжээ 1: Хувь сонирхлын гол бүлгийн төлөөлөгчдөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулж, удирдах хороо, төсөл боловсруулах үүрэгтэй ажиллуулах.
- Арга хэмжээ 2: Монгол Улсын Компанийн засаглалын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл боловсруулах ажлын хэсгийг зохион байгуулах.
- Арга хэмжээ 3: Монгол Улсын Компанийн засаглалын дүрмийг эргэн хянах ажлыг гүйцэтгэж хувь сонирхлын бүхий л бүлгүүдийг оролцуулах, тэр дундаа дугуй ширээний хэд хэдэн удаагийн ярилцлага зохион байгуулж оролцоог нэмэгдүүлэх, мөн түүнчлэн компанийн засаглалын зарчим, үндсэн чиглэлийн багц баримт бичгийг боловсруулж, улсын хэмжээнд дэмжүүлэн хэрэгжүүлж, нэгдсэн ойлголт, харилцан тохиролцоонд хүрэх ажлыг эхлүүлэх.
- Арга хэмжээ 4: Монгол Улсын компанийн засаглалын дүрмэнд үндэслэсэн байнгын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, олон нийтийн ашиг сонирхол бүхий бүх байгууллагын захирлууд, ажилтнууд болон хөрөнгө оруулагч, зохицуулагч нарыг хамруулах.

2. Зохицуулалтыг хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллагууд нь компанийн засаглалтай холбоотой хүчин төгөлдөр буй хууль ээрх зүй, зохицуулалтын тогтолцоо, мөн түүнчлэн Монгол Улсын компанийн засаглалын дүрмийг бодит байдал дээр хатуу чанд мөрдүүлэх үүрэгтэй.

- Арга хэмжээ 1: МБ, СЗХ, ТӨХ, МХБ-ийн удирдах албан тушаалтнууд банк, аж ахуйн нэгжүүдийн үндсэн эзэмшигчид, ТУЗ-ийн дарга, гол гишүүдтэй уулзаж ярилцан бүх хууль тогтоомж, дүрэм журам, мөн түүнчлэн Монгол Улсын компанийн засаглалын дүрмийг дагаж мөрдөх, компанийн засаглал, түүнтэй холбоотой асуудлаар зайлшгүй мэдэх ёстой зүйлийн сургалтанд хамрагдахыг хатуу уриалах ёстой. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сургалтанд хамруулахгүй байснаар сургалтанд албан журмаар хамрагдах шаардлага үүсэхийг цаад утгаараа ойлгосон байна.
- Арга хэмжээ 2: МБ, СЗХ, ТӨХ, МХБ нь Монгол Улсын компанийн засаглалын дүрэм болон нэг салбарт мөрдүүлэхээр тусгайлан гаргасан компанийн засаглалын журмыг дагаж мөрдөж байгаа байдалд хяналт тавихдаа сонор сэрэмжтэй байж, компанийн засаглалыг зохих ёсоор хэрэгжүүлэх нөхцлийг хангах ёстой. СЗХ-ноос МХБ-тэй хамтран компанийн засаглалын мэдээ мэдээллийг нээлттэй болгох жишиг загварыг боловсруулан Интернетэд тавьж, бүх компаниудад, нэн ялангуяа хувьцаа нь хөрөнгийн бирж дээр идэвхтэй арилжаалагддаггүй компаниудад компанийн засаглалын мэдээ мэдээллийг нээлттэй болгох бодлогод нь чиглэл болгож болох талтай.
- Арга хэмжээ 3: Сургалтанд байнга анхаарал хандуулж компанийн албан тушаалтан, зохицуулагч, хөрөнгө оруулагч нарт зориулан сургалт явуулж компанийн засаглалын мэдээ мэдээллийг нээлттэй болгох ажлыг хэрхэн зохистой тайлагнах, мөн хянан үзэх арга техникт сургах хэрэгтэй.

3. Компанийн засаглалын тогтолцоог нийтлэг жишигт нийцүүлэх үүднээс хууль эрх зүй, зохицуулалтын тогтолцоонд хэд хэдэн нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай.

- Арга хэмжээ 1: Хувь сонирхлын гол бүлгийн төлөөлөгчдөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулж, удирдах хороо, төсөл боловсруулах үүрэгтэй ажиллуулах.
- Арга хэмжээ 2: Ажлын хэсгээс энэхүү тайлан, өөрийн судалгаа шинжилгээнд үндэслэн хууль эрх зүйн орчинд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулах.
- Арга хэмжээ 3: Нэмэлт өөрчлөлтүүдийн төслийг оролцогч талуудад танилцуулж санал авах; санал дүгнэлтүүдийг

зохих ёсоор хүлээн авч, Интернетэд тавих.

4. МХБ, СЗХ-ноос хөрөнгийн биржид бүртгүүлэхэд тавьдаг шалгуурыг нэмэгдүүлж, үргэлж мөрдүүлэхийн зэрэгцээ хөрөнгийн зах зээлд итгэх итгэлийг сэргээх үүднээс шаардлага хангаагүй компанийг бүртгэлээс хасах арга хэмжээ авч эхлэх нь чухал.

- Арга хэмжээ 1: Шаардлага хангаагүй компаниудыг бүртгэлээс хасах хамгийн оновчтой арга замын талаар шилжилтийн бусад орнуудын олж авсан сургамжийн талаар судалгаа хийхийн хажуугаар хувьцаа эзэмшигч нарын эрхийг хүндэтгэх. Судалгааны хүрээнд дараах асуудлуудад анхаарлаа хандуулах нь зүйтэй. Үүнд:
 - Үйл ажиллагааны онцлогоос хамараад хуулийн өөр хэлбэрээр зохион байгуулагдвал илүү оновчтой байх компаниудыг үр дүнтэй хөрвүүлэх, мөн түүнчлэн СЗХ-ны хяналтан үйл ажиллагаагаа явуулах шаардлагатай компаниудын тоог багасгах бусад арга хэмжээг авах “шилжилтийн зам”.
 - Шаардлага хангаагүй компаниудыг бүртгэлээс хасахын хажуугаар хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн эдлүүлэх талаар бусад орнуудын хуримтлуулсан туршлага.
 - Биржид бүртгэлтэй компаниудад тавих шалгуур үзүүлэлтүүдийг шинээр тогтоож, SCSSM-аас илүү хяналт тавих.
- Арга хэмжээ 2: Судалгааны үр дүнгээр гарсан зөвлөмжийг, тэр дундаа МХБ-ээс тавьдаг шаардлагыг хангаагүй болоод хувьцааны арилжаа идэвхтэй явагдахгүй байгаа компаниудыг бүртгэлээс хасах тухай зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах.

Монгол Улсын компанийн засаглалын тогтолцоонд OECD-гийн зарчмуудын 1-р бүлгээс хэрэгжихгүй байгаа зарчмуудын хэрэгжилтийг хангах үүднээс Монгол Улсын Засгийн газар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Үүнд:

Богино хугацаанд хүрэх эн тэргүүний зорилтууд

- СЯ, МБ, СЗХ, МХБ зэрэг улсын секторын гол агентлагууд болон бусад байгууллагууд компанийн засаглалтай холбоотой арга хэмжээ зохион байгуулах буюу оролцож, энэ асуудлаар мэдээ материал хэвлэн гаргаж, компанийн сайн засаглалтай болох бизнесийн хэрэгцээ шаардлагыг дэмжих замаар олон нийтийн дунд ухуулан сурталчилгаа хийх.
- МБ-наас банкны салбарын компанийн засаглалын дүрэм журмын мөрдөлтийг хангаж, хурал зөвлөлгөөн, сургалт семинар зохион байгуулахад туслалцаа үзүүлэх замаар компанийн засаглалын зарчмуудын мөрдөлтийг хангахад дэмжлэг үзүүлэх. МБ хамгийн сүүлд хийгдсэн Санхүүгийн салбарын үнэлгээний хөтөлбөрт тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх.¹⁹ МБ-ны ажилтнуудыг компанийн засаглалын сургалтанд хамруулж, компанийн засаглалыг албан ёсоор хяналт шалгалтанд хамруулах.
- СЗХ-ноос санхүүгийн зуучлагч нарт тавьж буй дүрэм журмын хэрэгжилтийн шаардлага, арга хэмжээг нэмэгдүүлж дотоод мэдээллийг ашиглаж биржийн арилжаанд оролцох, зах зээлээр тоглох явдлын хүрээг хумихад анхаарах. Энэ зорилгоор СЗХ-нд хуваарилж буй хөрөнгө нөөц хангалттай эсэхэд дахин үнэлгээ хийж, тавьсан зорилтоо хангах нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай байна (Засгийн газраас хамааралгүй бие даасан байх зарчмыг богино хугацаанд алдагдуулсан ч гэсэн энэ чиглэлээр ажиллах хэрэгтэй). СЗХ нь ерөнхийдөө хууль дүрмийг ханган мөрдүүлэх ажлыг хариуцах.
- СЗХ-ны боловсон хүчин, ур чадвар, цалин хөлсийг тус салбарын хэрэгцээ шаардлагаас гадна гадаад орны ижил төстэй зохицуулагч байгууллагуудын туршлагад нийцүүлэхэд анхаарах хэрэгтэй. СЗХ-ны ажилтнуудыг сургалтанд хамруулах, ялангуяа гадаадын туршлагатай зохицуулагч байгууллагууд дээр сургалтанд хамруулах нь эн тэргүүний асуудал байх учиртай.

¹⁹ ОУВС-гийн гишүүн орны тайлан № 08/300. Монгол Улс: Санхүүгийн системийн тогтвортой байдлын үнэлгээ, 2008 оны 9-р сар.

**Дунд хугацаанд хүрэх эн
тэргүүний зорилтууд**

- МХБ-ээс компаниудад дээр авч хэрэгжүүлж буй мөрдөлтийг хангах арга хэмжээг чангатгаж, биржид бүртгэлтэй байхад тавих шалгуурыг хэрэгжүүлэх. Компаниудын хөрөнгө нөөцийг дахин үнэлж тавьсан зорилтдоо хүрэх нөхцлийг хангах. МХБ хууль дүрмийг мөрдүүлэх үйл ажиллагааны хариуцлага хүлээх.
- СЗХ-ноос биржийн бүртгэлтээс хасахын хажуугаар хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах талаар бусад улсуудын туршлагыг судлах.
- СХЗ-ноос Монгол Улсын Компанийн засаглалын дүрмийн мөрдөлт компаниуд дээр ямар байгаа талаар жилийн тайлан гаргах.
- МХБ-ээс хөрөнгийн биржид бүртгүүлэх шалгуурыг чангатгаж, биржийн бүртгэлтээс хасах арга хэмжээ авах.
- МХБ өөрөө үлгэр дуурайлал болж Монгол Улсын Компанийн засаглалын дүрмийг дагаж мөрдөх.
- Хууль тогтоогч, зохицуулагч бүхий л байгууллагууд шинээр батлагдсан хууль тогтоомж, тэдгээрийн заалтуудын талаар санал дүгнэлт гаргуулж авах талаар идэвхтэй ажиллаж, танилцуулан тайлбарлах дугуй ширээний ярилцлага зохион байгуулж, саналыг нь цуглуулан дэмжлэг олон авч, санал дүгнэлтүүдийг Интернет дээр тавьж нээлттэй болгох. Нэн ялангуяа, Монгол Улсын Компанийн засаглалын дүрмийг олон нийтээр дахин хэлэлцүүлж, ухуулан сурталчилан улсын секторын дэмжлэгийг олж авах арга хэмжээ авах.
- Хууль эрх зүй, зохицуулалтын тогтолцоонд нэмэлт өөрчлөлт оруулж, хууль дүрэм хэрэгжүүлэгч бүхий л байгууллагуудыг үүрэг ролийг тодорхой болгож, тайлагнах тогтолцоог тодорхойлон, үүрэг хариуцлагыг зааж өгөх. Мөн түүнчлэн хууль тогтоомж, дүрэм журмыг компанийн төрөлд тус бүрт тохируулан боловсруулах, хэрэгжүүлэх боломжтой байх, эдийн засгийн гүйцэтгэлд хүссэн үр дүн авчрах нөхцлийг хангах.
- ЖДҮ-үүд санхүүгийн тайлан гаргахдаа СТОУС-ыг дагаж мөрдөх үүрэг хүлээхгүй байх.
- Зохицуулагч болон түүнтэй төстэй бүхий л байгууллагууд үйл ажиллагаа, ялангуяа хууль дүрмийг хэрэгжүүлэх арга хэмжээгээ илүү ил тод болгох.
- Хууль дүрэм хэрэгжүүлэгч бүхий л байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог бодит байдал дээр бэхжүүлэх.
- Монгол Улсын компаниудын ихэнх хэсэг нь ЖДҮ байдаг учраас Монгол Улсын Компанийн засаглалын дүрмэнд жижиг, хөрөнгийн биржид бүртгэлгүй, гэр бүлийн эзэмшлийн аж ахуйн нэгжүүдэд хамаарах компанийн засаглалын асуудлыг тусгасан хэсэг оруулж, цуврал төлөвлөлт гэх мэт холбогдох асуудал дээр анхаарах.
- СЗХ-ны цахим хуудсан дээр байгаа "төслийн хэлэлцүүлэг" буланг шинэчилж, олон нийтийн хэлэлцүүлгийг өрнүүлэх зорилгоор тогтмол ашиглаж байх.

**Урт хугацаанд хүрэх эн
тэргүүний зорилтууд**

Монгол Улсын Компанийн засаглалын тогтолцооны OECD Зарчмуудыг 2-р бүлгийн заалтуудтай нийцэхгүй байгаа асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Монгол Улс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Үүнд:

**Богино хугацаанд хүрэх
эн тэргүүний зорилтууд**

- Компанийн тухай хуулинд дараах байдлаар нэмэлт өөрчлөлт оруулах: (1) ногдол ашиг хуваарилах асуудлыг ТУЗ-ын санал болгосноор хувьцаа эзэмшигчид баталдаг байх; (2) хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр ТУЗ-ийн гишүүдээс албан ёсоор асуулт асуух боломжийг хувьцаа эзэмшигчдэд олгох, (3) ТУЗ-ийн бүх гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулж, асуултанд хариулахыг шаардах.
- СЗХ-ноос хуульд заасны дагуу ногдол ашгийг брокеруудаар жижиг хувьцаа эзэмшигчдэд хуваарилуулах арга хэмжээ авах.

Дунд хугацаанд хүрэх эн тэргүүний зорилтууд

Урт хугацаанд хүрэх эн тэргүүний зорилтууд

- Компанийн тухай хуулинд дараах байдлаар нэмэлт өөрчлөлт оруулах: (1) Компанийг үүсгэн байгуулах дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулах, давуу эрхийг эдлүүлэхгүй байх зэрэг компанийн чухал шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн 2/3 саналаар гаргах; (2) компанийн дүрмийн санг нэмэгдүүлэх, шинээр хувьцаа гаргах шийдвэрийг ТУЗ-ийн санал дээр үндэслэн хувьцаа эзэмшигчдээр батлуулах; (3) хувьцаа эзэмшигчид гүйцэтгэх бус албан тушаалтны хөлс, гүйцэтгэх албан тушаалтны урамшууллын багцыг батлах эрхийг хувьцаа эзэмшигчдэд олгох, харин гүйцэтгэх албан тушаалтны цалинг батлах эрх ТУЗ-д байх; (4) групп компанийн дүрмийн сангийн бүтэц, хувьцаа эзэмшигчдийн гэрээ, саналын тусгай эрх зэргийг олон нийтэд нээлттэй болгох (эсвэл Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, хөрөнгийн биржид бүртгүүлэхэд тавих шалгуурын хүрээнд тогтоох буюу Монгол Улсын Компанийн засаглалын дүрэмд тусгаж өгөх); (3) ТУЗ-ийн гишүүдийн эрх мэдэл солигдох үед хувьцаа эзэмшигчдийн өмнө анхаарал, үнэнч байдлын талаар хүлээх тусгай үүргийг зааж өгөх; (4) хувьцаа эзэмшигчдийн үндсэн эрхтэй холбоотой асуудлуудаар харилцан зөвлөлдөх боломжийг хувьцаа эзэмшигчдэд гаргаж өгөх.
- Монгол Улсын Компанийн засаглалын дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулж, зохион байгуулалттай хөрөнгө оруулагч нарыг санал өгөх бодлогоо тодорхойлох, бодитоор санал өгөх, санал өгөх бодлого, санал өгсөн байдлаа олон нийтэд мэдээлэхийг нь дэмжих. Мөн түүнчлэн эдгээр хөрөнгө оруулагч нар хөрөнгө оруулсан компаниудынхаа компанийн засаглалын боловсронгуй болгоход туслалцаа дэмжлэг үзүүлэх учиртай. Эцэст нь, зохион байгуулалттай хөрөнгө оруулагч нар ашиг сонирхлын зөрчилдөөнийг шийдвэрлэх бодлого тодорхойлж, олон нийтэд зарлах нь зүйтэй.

Монгол Улсын Компанийн засаглалын тогтолцооны OECD Зарчмуудыг 3-р бүлгийн заалтуудтай нийцэхгүй байгаа асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Монгол Улс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Үүнд:

Богино хугацаанд хүрэх эн тэргүүний зорилтууд

Дунд хугацаанд хүрэх эн тэргүүний зорилтууд

Урт хугацаанд хүрэх эн тэргүүний зорилтууд

- ТУЗ-ийн гишүүд болон ажилтнууд компанийнхаа үнэт цаасаар арилжаа хийхийг хориглосон тодорхой хаалттай хугацаа гэж байх ёстой бөгөөд энэ хугацааг хувьцаа эзэмшигчид, бусад этгээдэд цаг алдалгүй мэдээлж нээлттэй болгосон байх.
- СЗХ-ноос холбогдох этгээдийн ажил гүйлгаа, арилжаа үүсэхээс сэргийлж, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг хатуу чанд хэрэгжүүлнэ.
- Компанийн тухай хуулинд дараах байдлаар нэмэлт өөрчлөлт оруулах. Үүнд:
 - Хувьцааны өөр өөр төрлийн цуврал, ангиллын саналын эрхийг өөрчлөх саналыг хувьцаа эзэмшигчдээр батлуулах.
 - Компаниуд өөрийн хувьцааны ангилал, цувралын талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох.
 - Компанийн нийт хувьцааны нэг буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч уламжилсан нэхэмжлэл гаргах бололцоотой байна гэсэн хуулийн заалт нийт хувьцааны нэг хувийг эзэмшиж байгаа нэг хувьцаа эзэмшигч эсвэл хувьцаа бүлэг эзэмшигчдэд хамаарахыг тодруулах.
- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж, компанийн хууль ёсны өмчлөгч нар өөрсдийн асран хамгаалагч нарт саналаа хэрхэн өгөхийг зааварлах бололцоог гарган өгч, асран хамгаалагч нарыг санал өгөх бодлогоо тодорхойлж, нийтэд нээлттэй болгохыг шаардах.

Монгол Улсын Компанийн засаглалын тогтолцооны OECD Зарчмуудыг 4-р бүлгийн заалтуудтай нийцэхгүй байгаа асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Монгол Улс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Үүнд:

Богино хугацаанд хүрэх эн тэргүүний зорилтууд

- Компаниуд шүгли үлээх бодлогыг хэрэгжүүлж, ажилчиддаа компанийн буруу, өөрөөр хэлбэл хууль бус болоод ёс зүйгүй үйлдлийн талаар мэдээлэхийг хөхиүлэн дэмжихийг хууль эрх, зохицуулалтын тогтолцооны дагуу шаардах буюу Монгол Улсын Компанийн засаглалын дүрэмд зааж өгөх. Компанийн ажилтнууд өшөө авахаас сэргийлж шүгли үлээгч нарыг хамгаалсан байна.
- Хууль дүрэм хэрэгжүүлэгч холбогдох бүхий л байгууллагууд хувь сонирхлын бүлгийн, нэн ялангуяа ажилтчид, зээлдүүлэгчид, байгаль орчин зэргийн эрхийг тогтмол хэрэгжүүлэх нөхцлийг хангах.

Дунд хугацаанд хүрэх эн тэргүүний зорилтууд

- Компаниас үүсгэн байгуулсан тэтгэврийн сангийн үйл ажиллагаанд бие даасан, хараат бус итгэмжит өмчлөгч хяналт тавих нөхцлийг хууль эрх зүй, зохицуулалтын тогтоцооны хүрээнд хангах. Итгэмжит өмчлөгч нь уг санг нийт хамрагдагчдын эрх ашигт нийцүүлэн дирдах үүрэгтэй.
- Ажилчид, зээлдүүлэгчид зэрэг гол оролцогч талуудад (найджартай, цаг хугацааны хувьд хоцрогдоогүй) мэдээллийг гаргах өгөх нөхцлийг хууль эрх зүй, зохицуулалтын тогтоцооны хүрээнд хангаж, тэдээрийн засаглалын үйл явцад оролцох бололцоог нь нэмэгдүүлэх.

Урт хугацаанд хүрэх эн тэргүүний зорилтууд

- Монгол Улсын Засгийн газраас Төлбөрийн чадваргүйдэл ба зээлдүүлэгчийн эрхийн ROSC үнэлгээг хийлгэж, Дэлхийн Банкны Бизнес эрхлэхүйн “бизнесийг хаах” үзүүлэлтийн зэрэглэлээ сайжруулах. 2009 оны байдлаар 108-рт байсан.

Монгол Улсын Компанийн засаглалын тогтолцооны OECD Зарчмуудыг 5-р бүлгийн заалтуудтай нийцэхгүй байгаа асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Монгол Улс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Үүнд:

Богино хугацаанд хүрэх эн тэргүүний зорилтууд

- СТОУС-ыг зөвхөн олон нийтийн ашиг сонирхол бүхий аж ахуйн нэгжүүд дагаж мөрдөх; СЯ-наас хөрөнгийн биржид бүртгэлгүй компани, ЖДҮ-үүдэд зориулсан нягтлан бодох бүртгэлийн хялбарчилсан стандартыг боловсруулах.
- Монгол Улсын Засгийн газар нь СТОУС, АОУС-ыг “нийцүүлж өөрчлөх” биш харин “баталж мөрдүүлэх” учиртай. Өөрөөр хэлбэл, НББОУХ-ноос гаргасан СТОУС, IFAC-аас гаргасан АОУС-ыг нягтлан бодох бүртгэлийн үндэсний стандартад нийцүүлэн өөрчлөхийн оронд батласан байдлаар нь мөрдүүлэх.
- Хууль дүрмийг хэрэгжүүлэгч эрх бүхий бүх байгууллагууд MD&A-ийн зэрэгцээ үйл ажиллагааны жилийн тайлангийн хүрээнд санхүүгийн тайлан тэнцлийг хуулийн хугацаанд нийтэд мэдээлэх үргийг хатуу чанд мөрдүүлэх.
- Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны хүрээнд Сангийн яам нь дараах нөхцлийг баталгаажуулах. Үүнд: (1) аудиторуудын аудитын үйл ажиллагаагаа явуулахдаа, нэн ялангуяа үйлчлүүлэгчиддээ аудитын бус үйлчилгээ үзүүлэх болон үйлчлүүлэгчдийнхээ санхүүгийн тайлан тэнцлийг гаргахдаа бие даасан, хараат бус байх; (2) АОУС, IFAC-ийн Ёс зүйн дүрмийг баримтлах. Сангийн яам нь шийтгэл, хариуцлагын арга хэмжээ авах боломжтой байх.

Дунд хугацаанд хүрэх эн тэргүүний зорилтууд

- Монгол Улсын Компанийн засаглалын дүрэмд дараах зүйлүүд тусгагдсан байх. Үүнд: (1) шаардлагатай үед чухал ач холбогдолтой мэдээллийг хуулийн хугацаанд багтаан нийтэд мэдээлэх; (2) чухал ач холбогдолтой мэдээ мэдээллийг цахим хуудсанд байршуулах буюу үйл ажиллагааны (мэдээ мэдээллийн агууламж ихтэй) жилийн тайлан гаргах; (3) тухайн аудитор нь хараат бус байж, ажлаа мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэсэн, анхаарал болгоомжтой ажилласан талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх. Аудитын үйлчилгээний хөлсний дүнг мөн хувьцаа

ЭЗЭМШИГЧДЭД МЭДЭЭЛЭХ.

- Сангийн яам, СЗХ, МБ, МУМНБХ нь СТОУС-ын сургалтын нарийвчилсан бөгөөд тогтвортой үргэлжлэх хөтөлбөрийг боловсруулахыг уриалж, зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх. Нягтлан бодогч, аудитор, хөрөнгө оруулагч, зохицуулагч нар уг сургалтанд хамрагдах.
- Сангийн яам, NCSM Үндэсний хорооноос IFAC-ийн Ёс зүйн дүрмийг аудитын мэргэжлийн албан ёсны стандарт хэмээн хүлээн зөвшөөрөх. Харин МУМНБХ нь IFAC-ийн Ёс зүйн дүрмийг батлан гаргах эрхтэй болох.
- СЗХ нь санхүүгийн бус мэдээ мэдээллээс нийтэд мэдээлэх нарийвчилсан стандартыг боловсруулах үүрэг хүлээх.
- МУМНБХ нь мэргэшсэн нягтлан бодогчийн шалгалтыг боловсронгуй болгох, нэн ялангуяа дээд шатны аудит, компанийн тайлан мэдээний асуудлыг хамрадаг болох.
- Сангийн яамнаас хэрэгжүүлдэг чанарын хяналтын үйл ажиллагаа, эцэст нь бие болох ёстой бие даасан хяналтын байгууллагаас гадна өөрийн гишүүдийн үйл ажиллагааны чанарыг баталгаажуулах эрхийг МУМНБХ-д хуулийн дагуу олгох.
- Компанийн тухай хуулинд дараах байдлаар нэмэлт өөрчлөлт оруулах. Үүнд: (1) хөндлөнгийн аудиторыг ТУЗ өөрөө биш харин ТУЗ-ийн санал болгосноор хувьцаа эзэмшигчид сонгодог болохыг зааж өгөх; (2) Хөндлөнгийн аудиторын эсрэг хүчин төгөлдөр буюу dissuasive арга хэмжээ авч, торгууль ногдуулж, эсвэл хариуцлага тооцож болох.
- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулинд дараах нэмэлт өөрчлөлтийг оруулж компаниудыг доорх үүрэгтэй болгох: (1) улирлын тайлан тэнцлийг хувьцаа эзэмшигчдэд гаргаж өгөх; (2) IOSCO-гаас Үнэт цаасны худалдах чиглэлийн шинжээчийн ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэх талаар гаргасан зарчмын тодорхойлолтуудыг хэрэгжүүлэх; (3) компанийн ТУЗ нь хөндлөнгийн аудиторын хараат бус бие даасан байдал, мэргэжлийн ур чадварыг өөрсдөө баталгаажуулах үүрэгтэй бөгөөд мөн хэмжээний мэдээ мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд мэдээлж байх.
- Аудитын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж, аудитын компанийг бүхэлд нь бус харин түүний тэргүүлэх гишүүнийг тодорхой давтамжтайгаар сольж байх.
- Компанийн хяналтын одоогийн тогтолцоонд буй хяналтын зөвлөлийн гүйцэтгэх үүрэг ролийг, нэн ялангуяа аудиторуудыг эцсийн дүндээ хувьцаа эзэмшигчид баталдаг бол тэдгээрийн гүйцэтгэж буй хөндлөнгийн чиг үүрэг, мөн аудитын хорооны үйл ажиллагаатай харьцуулан Засгийн газраас дахин үнэлэх.
- Урт хугацаанд авч үзвэл Монгол Улсын Засгийн газраас аудиторын хараат бус бие даасан байдлыг хянах үүрэг бүхий бие даасан хяналтын байгууллага байгуулах. Одоогоор энэ мэргэжилд тавих хяналтыг Сангийн яам хэрэгжүүлж байгаа бөгөөд богино болон дунд хугацаанд чанарын хяналтыг хэрэгжүүлэхийн тулд Сангийн яаманд хөрөнгө нөөц нэмж гаргаж өгөх.
- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн хүрээнд цаашид IOSCO-аас гаргасан Зээлийн зэрэглэлийн байгууллагын үйл ажиллагааны тухай зарчмын тодорхойлолтыг хэрэгжүүлэх.

 Урт хугацаанд хүрэх эн тэргүүний зорилтууд

Монгол Улсын Компанийн засаглалын тогтолцооны OECD Зарчмуудыг 5-р бүлгийн заалтуудтай нийцэхгүй байгаа асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Монгол Улс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Үүнд:

Богино хугацаанд хүрэх
эн тэргүүний зорилтууд**Б**унд хугацаанд хүрэх эн
тэргүүний зорилтууд**Б**урт хугацаанд хүрэх эн
тэргүүний зорилтууд

- МУКЗД-д дараах нэмэлт өөрчлөлтийг оруулах. Үүнд: (1) Компанийн тухай хуулинд заасан анхаарал болгоомж, үнэнч байх тухай үүргийг тусгаж өргөжүүлэх; (2) ТУЗ-өөр Ёс зүйн дүрмийг батлуулах, уг дүрмийг олон нийтэд мэдээлэх, мөрдөлтийн талаар тодорхой давтамжтайгаар мэдээлэх; (3) гүйцэтгэх удирдлагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд сайн удирдамж болж өгөх, нэн ялангуяа ТУЗ-ийн удирдлагад стратегийн удирдамж өгч хяналт тавих, компанийн засаглалын бодлогыг хянах, үргэлжлэх бодлогыг батлах талаар гүйцэтгэх үүрэг роль; (4) хорооны гишүүдийн ажлын даалгавар, бүтцийг мэдээлэх; (5) ТУЗ-ийн гишүүний томилогдсон хугацаа, ажил эрхлэлт ба орлого, ТУЗ-ийн бусад албан тушаалууд, ТУЗ, хорооны гишүүдийн хуралд оролцсон байдлыг мэдээлэх; (6) ТУЗ-ийн гишүүдийг чиглэл олгох болоод мэргэжил дээшлүүлэх сургалтанд тогтмол хамруулах; (7) ТУЗ-д үнэн зөв, зохистой, хоцрогдоогүй мэдээ мэдээлэл гаргаж өгөх, ТУЗ-ийн гишүүдийн анхаарал тавих үүргийн хүрэнд эдгээр шаардлагыг хангасан мэдээ мэдээллийг гаргаж өгөхийг шаардах; (8) ТУЗ-ийн бие даасан гишүүний тодорхойлолтыг боловсронгуй болгох; (9) хараат бус бие даасан зөвлөлгөөг гаднаас чөлөөтэй авах боломжийг ТУЗ-ийн гишүүдэд гаргаж өгөх.
- Компанийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж, (1) ТУЗ-ийн гишүүдийг нийт хувьцаа эзэмшигчид, тэр дундаа жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийн үүднээс ажиллуулах; (2) ТУЗ-ийн гишүүдийн тоог есөөр тогтоохын оронд хамгийн цөөндөө 3 эсвэл 5 байхаар заах.
- Төрийн өмчит аж ахуйн нэгжийн ТУЗ-ийн гишүүнээр засгийн газрын бус албан тушаалтныг томилж, бие даасан гишүүнтэй байх.
- Компанийн засаглалын байгууллагууд үүсэн хөгжиж байгаатай холбогдуулан ТУЗ-ийн гишүүд, бусад албан тушаалтнуудад зориулан компанийн засаглалын сургалт явуулах сайн чанарын сургалтын хүчин чадлыг бүрдүүлэхэд, нэн ялангуяа сургалтыг дотооддоо тогтвортой явуулах чадавхийг бий болгох зорилгоор бүх хувь сонирхлын этгээдүүд дэмжлэг үзүүлэх.
- Компанийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж, хяналтын зөвлөлийг сайн дурын үндсэн дээр зохион байгуулах эрхийг компаниудад олгох.



THE WORLD BANK

Энэхүү тайлан нь Стандарт, дүрэм журмын хэрэгжилтийн байдалд өгсөн үнэлгээ (ROSC)-ний хөтөлбөрийн хүрээнд гишүүн орны компанийн засаглалд хийсэн цуврал үнэлгээний нэг юм. Компанийн засаглалын ROSC үнэлгээний хүрээнд хууль эрх зүй, зохицуулалтын тогтолцоо, хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн дүрэм журмыг хэрэгжүүлж хангасан байдал болон Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас гаргасан Компанийн засаглалын зарчмуудыг хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд хэрхэн ханган биелүүлж байгаад дүн шинжилгээ хийдэг.

ROSC үнэлгээнд:

- Компанийн засаглалын тогтолцоог үндэсний хэмжээнд үнэлэхдээ нэгдсэн аргачлал ашигладаг
- Харьцуулалт хийх жишгийг гаргаж өгснөөр гишүүн орнууд өөрсдийгөө үнэлж компанийн засаглалд шинэчлэл хийх чиглэлээр ямар ахиц дэвшил гаргаж байгаагаа харах боломжтой
- Мэдээллийн хэрэглэгч, хөрөнгө оруулагч, зохицуулагч, олон нийтийн эрх ашигт хамаарах шийдвэр гаргагч нарын дунд үр бүтээлтэй харилцаа үүсгэж үнэлгээ хийгдэж буй улсуудад шинэчлэлийн арга хэмжээг өөрийн санаачлага, эрмэлзлэлээр хэрэгжүүлэх явдлыг бэхжүүлдэг
- Бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэх суурийг бүрдүүлж, бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлдэг

Өмнө нь нийтлэгдсэн ROSC үнэлгээний тайлангуудын бүрэн хэмжээний жагсаалтыг дараахь хаягаас авна уу:

http://www.worldbank.org/ifa/rosc_cg.html

Олон Улсын Санхүүгийн Корпораци, Дэлхийн Банкны цахим хуудаснаас компанийн засаглалын талаарх нэмэлт мэдээллийг авч болно. www.worldbank.org/corporategovernance/

Бидэнтэй холбоо барихыг хүсвэл CG-ROSC@worldbank.org цахим хаягаар захиа бичнэ үү.